

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН
ИЛ ТОД БАЙДАЛ, ЁС ЗҮЙ,
АВЛИГЫН АСУУДАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

The logo for Canada, featuring the word "Canada" in a black serif font with a small red and white Canadian flag icon above the letter 'a'.The logo for The Asia Foundation, consisting of a stylized circular emblem with two curved lines meeting at the center, resembling a traditional Asian motif.

The Asia Foundation

The logo for the Institute of International and Area Studies (UIH) at the Mongolian State University (MN), featuring the acronym "UIH MN" in large blue letters, a circular emblem with a globe, and the text "SIGA" in green below it. Below the main text, the Mongolian words "СУДАЛГААНЫ САН" are written in blue.

Энэхүү судалгааг Канадын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр явуулсан бөгөөд судалгааны үр дүн нь Канадын Гадаад хэргийн яам болон Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

This survey was undertaken with the financial support of the government of Canada provided through the Global Affairs Canada.

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДАЛ, ЁС ЗҮЙ, АВЛИГЫН АСУУДАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР

2016

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|------|--------------------------------------|
| АТГ | Авлигатай тэмцэх газар |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ТАШН | Түүврийн анхан шатны нэгж |
| МСҮТ | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв |

АГУУЛГА

| | |
|---|----|
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР | 4 |
| ОРШИЛ | 7 |
| ХУРААНГУЙ | 8 |
| БҮЛЭГ 1. Судалгааны зохион байгуулалт, арга зүй, оролцогчид | 11 |
| 1.1. Судалгааны зохион байгуулалт | 11 |
| 1.2. Тоон судалгаа | 11 |
| Тоон судалгаанд оролцогчдын мэдээлэл | 13 |
| 1.3. Чанарын судалгаа | 16 |
| Чанарын судалгаанд оролцогчдын мэдээлэл | 18 |
| БҮЛЭГ 2. Боловсролын үйлчилгээн дэх ёс зүй, авлигын асуудал | 19 |
| 2.1. Боловсролын үйлчилгээн дэх ёс зүй, авлигын талаарх ойлголт, төсөөлөл | 19 |
| 2.2. Боловсролын үйлчилгээн дэх авлигын тохиолдол | 23 |
| 2.3. Боловсролын үйлчилгээн дэх хандив тусламж, төлбөр хураамжийн талаарх ойлголт, төсөөлөл | 32 |
| 2.4. Боловсролын үйлчилгээн дэх хандив тусламж, төлбөр хураамжийн тохиолдол | 35 |
| БҮЛЭГ 3. Боловсролын байгууллагын ил тод байдал, ёс зүй, авлигын нөхцөл байдал | 48 |
| 3.1. Томилгоо, албан тушаал, шагнал урамшуулал | 48 |
| 3.2. Боловсролын салбарын төсөв, өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт | 50 |
| БҮЛЭГ 4. Ёс зүй, ашиг сонирхлын зөрчил, авлигын шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам | 53 |
| 4.1. Шалтгаан нөхцөл | 53 |
| 4.2. Урьдчилан сэргийлэх арга зам | 54 |
| ХАВСРАЛТ 1. Чанарын судалгаанд оролцогчдын жагсаалт | 55 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

I. ОРШИЛ

Азийн сан нь засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх, соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааныхаа хүрээнд Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгааг 2006 оноос, Бизнесийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааг 2012 оноос явуулж байгаа бол Эрүүл мэндийн үйлчилгээн дэх авлигын нөхцөл байдал судалгааг 2014 онд, Бизнесийн зарим салбар болон төрийн байгууллагын харилцаан дахь авлигын нөхцөл байдал судалгааг 2015 онд тус тус явуулаад байна.

Авлигын талаарх олон нийтийн төсөөллийн судалгаанаас үзэхэд улс төрийн намууд, газрын алба, уул уурхайн салбарт авлига их гэсэн ойлголт төсөөлөл нийтлэг байдаг. Харин эдгээртэй харьцуулахад боловсрол, эрүүл мэндийн салбар авлига багатайд тооцогдож байна. Түүнчлэн иргэд хууль шүүхийн байгууллагыг бодвол, боловсрол, эрүүл мэндийн салбарт өөрсдөд нь илүү шударга хандана гэсэн хүлээлттэй байна. Боловсролын салбарт авлигын нөхцөл байдал хүнд ноцтой биш хэдий ч бусад салбартай харьцуулахад хамрах цар хүрээ нь өргөн, тохиолдол нь илүү олон, иргэд, олон нийт ялангуяа хүүхэд залуучуудын ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна. Тухайлбал, 2012-2014 оны судалгаагаар авлига, хээл хахуультай тулгарсан гэх иргэдийн нийт тохиолдлын дунджаар 28 хувь¹ нь багш нартай холбогдож байв.

Азийн сан энэ удаад “Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх” төслийн хүрээнд Авлигатай тэмцэх газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамтай хамтран ажиллаж байгаа бөгөөд боловсролын салбар дахь ёс зүй, авлигын нөхцөл байдлыг илүү тодорхой болгох зорилгоор энэхүү судалгааг явууллаа. Судалгаагаар боловсролын салбар дахь ёс зүйн асуудлууд, авлигын төрөл хэлбэр, нөлөөлж буй шалтгаан нөхцөл, бусад хүчин зүйлүүдийн талаарх иргэд, салбарын багш, ажилтнууд, эксперт судлаачдын ойлголт, төсөөлөл, ажиглалт, тохиолдлыг судалсан бөгөөд мэдээллийг хөндлөнгийн дүгнэлт, анализгүйгээр танилцуулж байна. Судалгааг тоон болон чанарын гэсэн хоёр хэсгээр явуулж, судалгааны үндсэн мэдээллийг эцэг эхчүүдээс тоон судалгааны аргаар авсан бөгөөд, тоон судалгааны асуулгад багтаагүй асуудлаар дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл олж авах зорилгоор боловсролын салбарын багш, ажилтан, экспертүүдийг чанарын судалгаанд хамруулав. Чанарын буюу ярилцлагын аргаар цуглуулсан нэмэлт мэдээлэл нь олон нийт болон салбарын нөхцөл байдлыг бүрэн төлөөлөхгүй бөгөөд тоон судалгааны үр дүнг тодруулах, лавшруулах үүднээс тохиолдол, ажиглалт, кейс зэргийг судалгааны тайланд ашиглав.

Судалгааны ажлыг гүйцэтгэж, тайлан бичихэд хамтран ажилласан ЭС АЙ СИ ЭЙ ХХК, асуулгыг боловсруулахад санал зөвлөмж өгч, арга зүйн дэмжлэг үзүүлсэн Авлигатай тэмцэх газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Нийслэлийн боловсролын газарт талархал илэрхийлье. Авлигаас урьдчилсан сэргийлэх, ёс зүй, ил тод байдлын асуудлаар яриа, хэлэлцүүлэг өрнүүлэх, төр, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлэх үйл ажиллагаанд энэхүү судалгаа хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

¹ Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох 2012 оны судалгаагаар сүүлийн 3 сард хээл хахууль өгсөн гэх 152 иргэний 31%, 2013 оны 3 сарын судалгааны 107 иргэний 22%, мөн оны 9 сарын судалгааны 102 иргэний 40%, 2014 оны 3 сарын судалгааны 19% нь багшид хээл хахууль өгсөн гэжээ.

ХУРААНГУЙ

Боловсролын салбар дахь ёс зүй, авлигын нөхцөл байдлын судалгааг Улаанбаатар хот болон бүсийн тулгуур төвүүд болох Дорнод, Дархан, Орхон, Ховд аймгуудад нийт 1240 хүний түүвэртэйгээр явууллаа. Судалгаанд боловсролын байгууллагаар үйлчлүүлэгчдийн төлөөлөл болох 1120 эцэг эх болон салбарын багш, ажилтан, эрдэмтэн судлаачдын төлөөлөл 120 иргэн хамрагдав. Хүүхэд нь боловсролын аль нэг шатлалын байгууллагад суралцдаг байх гэсэн шалгуурын дагуу оролцогчийг сонгож, олон шатлалт бүлэглэсэн түүврийн аргыг ашиглалаа. Боловсролын салбар дахь ёс зүй, авлигын талаарх оролцогчдын ойлголт, төсөөллийг тандах зорилгоор урьдчилан бэлтгэсэн сонголт бүхий үзүүлэлтүүдийг баллын үнэлгээний аргаар дүгнүүлэх, мөн чанарын буюу ярилцлагын аргаар нэмэлт мэдээлэл цуглуулав. Чанарын судалгааны мэдээлэл нь олон нийт болон салбарын нөхцөл байдлыг бүрэн төлөөлөхгүй бөгөөд үндсэн судалгааны үр дүнг тодруулах, лавшруулах, мөн харьцуулахад кэйс буюу тохиолдол, ажиглалтын мэдээллийг ашиглав. Судалгааны үр дүнг боловсролын үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаа, худалдан авалт гэсэн ерөнхий чиглэлүүдээр хураангуйлбал дараах байдалтай байна.

Боловсролын үйлчилгээн дэх ёс зүй, авлигын асуудал

Судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар боловсролын үйлчилгээний аль ч шатлалд ёс зүй, авлигын шинжтэй асуудлууд их байна. Эцэг эхчүүд боловсролын салбар дахь авлига, ашиг сонирхлын зөрчлийг 2.65 буюу “дунд зэрэг” гэж үнэлсэн бол салбарын багш, ажилтан, судлаачдын хувьд 3.37 буюу “их” гэсэн үнэлгээ өгч, илүү шүүмжлэлтэй хандаж байна. Сурагч, оюутныг загнах, гар хүрэх, гутаан доромжлох зэрэг ёс зүйн асуудлууд байсаар байна. Тухайлбал, оролцогчдын 30 орчим хувь нь сурагчдыг ялгаварлан гадуурхах, шударгаар үнэлэхгүй байх зэрэг асуудал их бий гэж үзжээ. Харин сургууль, цэцэрлэгт хүүхэд элсүүлэх, шинээр оруулах, анги өөрчлөх, сурлагын дүн, үнэлгээ өөрчлөхөд мөнгө, албан тушаал, танил тал ашиглах явдал нийтлэг байна. Тодруулбал, нийт оролцогчдын 50 орчим хувь нь ийм асуудал их байдаг гэсэн ойлголт, төсөөлөлтэй байна. Судалгаанд оролцогчдын хувийн туршлагыг судлахад тэдний 40 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд багш, ажилтанд хувьд нь бэлэг сэлт эсвэл мөнгө өгч, үйлчилгээ үзүүлжээ. Эдгээр тохиолдлын дийлэнх нь СӨБ, ЕБС-д хамаарч байна. Тодруулбал, цэцэрлэгийн хүүхэдтэй эцэг, эхчүүдийн 41 хувь нь хүүхдээ цэцэрлэгт анх удаа оруулах зорилгоор, ЕБС-д суралцдаг хүүхэдтэй эцэг эхчүүдийн 45 хувь нь сургууль, анги төгсгөсөнд талархал илэрхийлэх зорилгоор бэлэг сэлт, мөнгө өгсөн гэжээ. СӨБ болон ЕБС-д бэлэг сэлт өгөх тохиолдол илүү байгаа бол их, дээд сургууль, коллежийн түвшинд бэлэн мөнгө өгөх хандлага давамгайлж байна. Эдгээр тохиолдлуудын 80 гаруй хувьд нь эцэг эхчүүд өөрсдийн санаачилгаар бэлэг сэлт, мөнгө өгсөн байх бөгөөд тэдний 40 хувь нь хүссэн зүйлээ биелүүлсэн гэсэн бол 23 хувь нь тодорхой өөрчлөлт гараагүй, харин 35 хувь нь ямар нэг үр дүн хүлээгээгүй гэжээ. Бэлэг сэлтийн өртөг, мөнгөний хэмжээ шатлалаас хамаарч харилцан адилгүй байна. Талархал илэрхийлэхэд аль ч шатлалд дунджаар 40-50 мянган төгрөг байгаа бол цэцэрлэгт оруулахад хотод 400 мянга, ЕБС-ын суралцагчийг тэтгэлэгт хамруулахад 300 мянган төгрөг, их дээд сургууль, эсвэл анги өөрчлөхөд 500-800 мянган төгрөг төлсөн жишээтэй байна. Харин чанарын судалгааны мэдээллээс үзэхэд авлигад зарцуулсан гэх мөнгөний хэмжээ хэдэн сая төгрөгөөр хэмжигдэж байна.

Багш, ажилтанд талархах, давуу байдал олж авах зорилгоор бэлэг сэлт, мөнгө өгөх явдал нийтлэг байгаа ч ийм байдал цаашид үргэлжлэхийг эцэг эхчүүд буруу гэж үзэж байна. Гэвч энэ байдал хэвшсэн зүйл болж, нийтийг хамарсан учраас судалгаанд оролцогчид асуудлыг хэрхэн яаж өөрчлөх арга замын талаар тодорхой саналгүй, ирээдүйд өөрчлөгдөнө гэх итгэл үнэмшил муу байна. Тухайлбал тоон судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 70 орчим хувь нь бэлэг сэлт, мөнгө өгдөг байдал цаашид хэвээр байна эсвэл нэмэгдэнэ гэсэн гутранги төсөөлөлтэй байна.

Боловсролын салбар дахь хандив тусламж, төлбөр хураамжийн асуудал энэ судалгаанд мөн хамрагдсан. Салбарын хэмжээнд цэцэрлэг, сургуулийн орчин нөхцөл, суралцах үйл ажиллагаанд шаардлагатай эд материал, ном, сурах бичиг, давтлага дамжаатай холбоотой хандив, тусламж төлбөр хураамж авах явдал нийтлэг байна. Тоон судалгаанд оролцсон иргэдийн 50 гаруй хувь нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургууль, цэцэрлэгт хандив тусламж, төлбөр хураамж өгчээ. Нэг удаагийн хандив тусламж дунджаар 45 мянга орчим байгаа бол төлбөр хураамжийн дундаж нь 50 гаруй мянган төгрөг байна. Өгч буй хандив тусламжийн дийлэнх нь цэцэрлэг сургуулийн үйл ажиллагаанд чиглэж байгаа боловч, тохиолдлын дунджаар 10 орчим хувь нь эцэг эхчүүд өөрсдийн санаачлагаар, багш, удирдлагын хандлага өөрчлөх, хүүхдээ сургууль цэцэрлэгт оруулах гэх мэт өөр бусад зорилгоор өгсөн байна.

Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн 19.5 хувь нь ямар нэг бэлэг сэлт, мөнгө, хандив тусламж, төлбөр хураамж төлөөгүй байна. Өөрөөр хэлбэл цэцэрлэг, сургуулийн хүүхэдтэй 5 хүн тутмын 4 нь ямар нэг хэлбэрээр төлбөр, мөнгө өгсөн байна. Төлбөр, хураамжийг зориулалтаар нь харвал суралцах үйл ажиллагаатай шууд холбоотой үндсэн хичээлийн ном, сурах бичиг авах, хичээлээс гадуурх баяр ёслол, арга хэмжээний төлбөр зэрэгт авчээ. Харин салбарын хэмжээнд хандив тусламж, төлбөр хураамжийн зарцуулалт, тайлагнал хангалтгүй байна. Нийт тохиолдлын 40 орчим хувьд огт мэдээлэл өгөөгүй, 50 орчим хувьд нь багш мэдээлэл өгсөн, зөвхөн 10 хүрэхгүй хувьд нь тухайн сургуулийн удирдлага танилцуулсан байна. Эндээс үзэхэд салбарын хэмжээнд хичнээн хэмжээний хандив тусламж цуглардаг, төлбөр хураамж авдаг, тэдгээрийн зарцуулалтын талаар нэгдсэн мэдээллийг олон нийт авах боломжгүй байна. Хандив, тусламж, төлбөр хураамж бэлэн мөнгө хэлбэрээр багшид очдог, эсвэл багшаар дамжиж байгаа, зарцуулсан тайлан, мэдээлэл ил тод бус байгаа зэрэг нь ашиг сонирхлын зөрчил, авлига байна гэх хардлага сэрдлэгийг олон нийтийн дунд бий болгожээ. Төлбөр, хураамжийн асуудлаар салбарын хэмжээнд ямар нэг зохион байгуулалт хийсэн, арга хэмжээ авсан тухай мэдээлэл чанарын ярилцлагуудаас ажиглагдсангүй.

Боловсролын үйлчилгээн дэх ёс зүй, авлигын асуудлууд дийлэнх тохиолдолд эцэг эхчүүдийн хандлага, боловсролын салбарын төсөв, санхүүгийн боломж, цалин хангамж, ажиллах орчин нөхцөлтэй ихээхэн холбоотой байна. Асуудал боловсролын салбарт их бага хэмжээгээр хэвшил болсон бөгөөд буруу гэж үзэж байгаа ч хүлээн зөвшөөрсөн байдалтай байна. Нөгөө талдаа, бэлэг сэлт, хандив, тусламж, албан ба албан бус төлбөр хураамжийн талаарх нэгдмэл ойлголт бага, эдгээрийг зохион байгуулах, дагалдан гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгахад чиглэсэн захиргааны санаачлага, үйл ажиллагааны талаар төдийлэн дурдагдахгүй байна.

Боловсролын салбар дахь ёс зүй, авлигын асуудал

Судалгаагаар боловсролын салбар, байгууллагын дотоод үйл ажиллагаан дахь авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн асуудлыг голчлон чанарын судалгааны мэдээлэлд тулгуурлан судлав. Эндээс үзэхэд салбарын дотоод үйл ажиллагаанд давуу байдал олж авах, хувийн ашиг хонжоо хайх хандлага илүү давамгайлж байна. Тухайлбал, тоон судалгаанд оролцогчдын 50 гаруй хувь нь энэ салбарын хүний нөөцийн сонгон шалгаруулалт, албан тушаал дэвших, томилгоо, шагнал урамшуулал олгох үйл ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил “их” гэсэн төсөөлөлтэй байна.

Юуны өмнө салбарын удирдлага, ялангуяа сургуулийн захирлуудын ёс зүйн асуудал, мөн улс төрийн нам, албан тушаалтны зүй бус нөлөөлөлтэй холбоотой шүүмжлэлүүд багш, ажилтнуудын дунд их байна. Жишээлбэл, ажилд орох, албан тушаалын томилгоотой холбоотой авлигын тохиолдлууд цөөнгүй гардаг гэх бөгөөд чанарын судалгаанд оролцсон багш, ажилчдын 13 хувь нь энэ зорилгоор бэлэг сэлт, мөнгө өгч байснаа дурджээ.

Боловсролын салбарт ажиллагсад салбарын болон байгууллагын төсөв, санхүүгийн байдал, түүний ашиглалт зарцуулалтын талаар мэдлэг, мэдээлэл муутай байна. Байгууллагын төсөв, хөрөнгийн зарцуулалт, ялангуяа томоохон төсөл хөтөлбөр, худалдан авалтууд үр ашигтай, шударга, авлига хээл хахуульгүй гэж үзэх оролцогчид тун цөөн, харин хардлага, сэжиг таамаг давамгайлж байна.

Тоон судалгаанд оролцогч иргэдийн 46 хувь нь салбарын худалдан авах ажиллагаанд авлига их бий гэсэн төсөөлөлтэй байна. Харин хувийн хэвшлийн байгууллагууд худалдан авах ажиллагааны шударга байдлыг “дунд зэрэг” гэж үнэлсэн бөгөөд үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулах үйл явц авлигад хамгийн эрсдэл бүхий үе шатанд тооцогдож байна. Салбарын худалдан авах ажиллагаанд авлига, мөн өөрсдийн ажиглалт, бодит тохиолдлууд байгаа зэргийг хувийн хэвшлийнхэн хүлээн зөвшөөрч байна. Олонх тохиолдолд салбарын дунд, дээд шатны албан тушаалтнууд холбогдож байх бөгөөд тендертэй холбоотой авлигын дүн тухайн гэрээний үнийн дүнгийн 5-10 хувьтай тэнцүү байдаг байна. Тухайлбал, чанарын ярилцлагад оролцсон 13 аж ахуйн нэгжийн зургаа нь авлигын замаар худалдан авах ажиллагаанд нөлөөлж байсан гэжээ.

Тоон судалгаанд оролцогчдын 60 хувь нь боловсролын салбарт ёс зүйн зөрчил, авлигын шинжтэй асуудалд огт хяналт тавьж, хариуцлага тооцож чадахгүй байна гэж үзэж байна. Түүнчлэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхийн тулд нэн тэргүүнд хяналт, хариуцлага сайжруулах, үүний зэрэгцээгээр цалин урамшуулал, салбарын төсөв, санхүүжилтийг нэмэгдүүлэх, нээлттэй ил тод байдлыг хангах, боловсролын салбарыг улс төрийн нөлөөнөөс ангид байлгах, бүх талуудын ёс суртахууныг дээшлүүлэх ажлыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хэдийгээр авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг нэрлэж байгаа боловч авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудлууд буурна гэх итгэл үнэмшил бага, төр, захиргааны байгууллагад хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл байгаа эсэхэд эргэлзсэн хандлага ажиглагдаж байна.

БҮЛЭГ 1 СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРГА ЗҮЙ, ОРОЛЦОГЧИД

1.1 Судалгааны зохион байгуулалт

Судалгааны зорилго, судлах асуудал, хамрах хүрээ хязгаар зэргийг 2016 оны 4 сард Боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын яам, АТГ болон салбарын ТББ-ын төлөөлөл бүхий хэлэлцүүлгийн хүрээнд ярилцаж тодорхойлсон. Үүний дагуу асуулгыг Азийн сан, ЭС АЙ СИ ЭЙ ХХК-аас боловсруулж, АТГ болон Нийслэлийн боловсролын газар, салбарын ТББ-ын санал, зөвлөмжийг авч эцэслэсэн болно. Түүнчлэн бэлтгэл ажлын хүрээнд ЭС АЙ СИ ЭЙ ХХК-ийн судлаачдад хоёр удаагийн сургалтыг АТГ-аас зохион байгуулж, авлигын ойлголт, төрөл, хэлбэр, хууль тогтоомжийн мэдлэг олгосон.

Судалгааны мэдээлэл цуглуулах, үр дүнг нэгтгэх ажлыг 2016 оны 6-р сарын 10-аас 8-р сарын 15 хүртэлх хугацаанд гүйцэтгэж, мэдээллийг нэгтгэх, судалгааны тайланг хянан тохиолдуулах, эцэслэх ажлыг 2016 оны 9 сард зохион байгууллаа. Судалгааны мэдээлэл оруулах (шивэх), шалгах, засварлахад тооллого, түүвэр судалгааны CSPro багц программ, мэдээлэл оруулах хэрэгсэл (Data entry tools), “SPSS18.0” болон түүврийн бус алдааг багасгах зорилгоор double entry method ашиглав.

Судалгаа нь нийслэл хот болон дөрвөн аймгийг хамарсан үндэсний хэмжээний судалгаа бөгөөд боловсролын салбарын оролцогч талууд болох эцэг, эх, сурагч, оюутан, багш, ТББ-ын төлөөлөл, салбарын эрдэмтэн судлаач, хувийн хэвшлийн төлөөлөл, нийт 1240 хүнийг хамрууллаа. Судалгааны мэдээллийг тоон буюу асуулгын, чанарын буюу ярилцлагын хосолсон арга ашиглан цуглуулав. Эцэг эхчүүдээс асуулгын аргаар, харин бусад оролцогчдоос ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл авсан болно (Хүснэгт 1).

Хүснэгт 1

| № | Судалгааны төрөл | Түүврийн нэгж | Хамрах хүрээ | Түүврийн хэмжээ |
|---|------------------|-----------------------------------|--------------------------|-----------------|
| 1 | Тоон судалгаа | Иргэн /Эцэг эхийн төлөөлөл/ | Улаанбаатар хот, 4 аймаг | n=1120 иргэн |
| 2 | Чанарын судалгаа | Оюутнуудын төлөөлөл | Улаанбаатар хот, 4 аймаг | n=120 хүн |
| | | Боловсролын байгууллагын төлөөлөл | | |
| | | Төрийн бус байгууллагын төлөөлөл | | |
| | | ААН-ийн төлөөлөл | | |

1.2 Тоон судалгаа

Судалгааны түүврийн хэмжээг тогтооходоо хүүхэд нь аль нэг шатны боловсролын байгууллагад суралцаж буй эцэг, эхийг хамруулав. Түүвэрлэлтийг 95 хувийн магадлал ($Z=1.96$), тухайн үзэгдлийн илрэх магадлал ($P_0=0.39$), алдааны хязгаар (0.035), комплекс түүвэрлэлтийн загварын нөлөө (1.5), тэнцвэртэй байхаар тооцов. Судалгааны түүврийн хэмжээг дараах томъёоллын дагуу тооцно. Үүнд:

$$n = \left(\frac{z^2 \times P_0 \times (1 - P_0)}{e^2} \right) \times Deff \quad 1)$$

1. $Z =$ Хүсэж буй ач холбогдлын түвшинг тодорхойлсон статистик утга
2. $P_0 =$ Тухайн үзэгдлийн илрэх магадлал
3. $Deff =$ Кластерийн нөлөө (Тухайн түүврийн дизайны вариацийг энгийн санамсаргүй үеийн вариацийг харьцуулж тооцно.)
4. $e =$ Алдааны хязгаар

Дээрх томъёог ашиглан түүврийг тооцоолоход үндэсний хэмжээнд төлөөлж чадах түүврийн хэмжээ 1113 гарсан бөгөөд хот болон хөдөө гэсэн 2 түвшинд ангилсантай холбоотойгоор түүврийн хэмжээг 1120 болгон засварласан. Алдааны хязгаар болон бусад статистикийн нарийвчилсан үзүүлэлтүүдийг Хүснэгт 2-д харууллаа.

Хүснэгт 2. Түүврийн тооцоолол

| Үзүүлэлт | n | p | q | deff | z | se | cv |
|--|-------------------|------|------|------|------|-------|-------|
| Нийт | 1113 ² | 0.39 | 0.61 | 1.5 | 1.96 | 0.035 | 0.090 |
| Байршлын хувьд | | | | | | | |
| Хот | 557 | 0.39 | 0.61 | 1.5 | 1.96 | 0.050 | 0.127 |
| Хөдөө | 557 | 0.39 | 0.61 | 1.5 | 1.96 | 0.050 | 0.127 |
| Сургалтын байгууллагын хэлбэрийн хувьд | | | | | | | |
| СӨБ | 371 | 0.39 | 0.61 | 1.5 | 1.96 | 0.061 | 0.156 |
| ЕБС | 371 | 0.39 | 0.61 | 1.5 | 1.96 | 0.061 | 0.156 |
| Их дээд, мэргэжлийн боловсрол | 371 | 0.39 | 0.61 | 1.5 | 1.96 | 0.061 | 0.156 |

Судалгаанд хамрагдах иргэдийг Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг болон бүс бүрээс нэг аймгийг төлөөлүүлэн олон шатлалт бүлэглэсэн түүврийн (multi stage stratified sampling) аргаар сонгсон. Судалгааны түүврийн хуваарилалтыг өрхийн тоонд тулгуурлан гаргасан. Өөрөөр хэлбэл нэг өрхөд аль нэг шатлалын боловсролын байгууллагад суралцдаг нэг хүн байна гэж таамагласан. Дээрх түүврийн хуваарилалтад үндэслэн Улаанбаатар хот болон бүсүүдэд хуваарилсан (Хүснэгт 3). Ингэхдээ дүүрэг болон бүсэд тэнцүү тоогоор хуваарилсан бөгөөд энэ нь салбар дахь авлигын нөхцөл байдлыг үндэсний хэмжээнд, хот ба хөдөө, мөн СӨБ, ЕБС, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол гэсэн түвшинд харьцуулан судлах боломжийг бүрдүүлсэн. Түвшин тус бүрийн алдааны хязгаарын утгыг Хүснэгт 2-оос харж болно.

Судалгаанд хамрагдах аймаг буюу бүсийн төлөөллийг сонгохдоо бүсийн тулгуур төвийг сонгосон бол хамрагдах сумыг санамсаргүй байдлаар сонгосон. Улаанбаатар хот болон 4 бүсийн тулгуур төв болох Дорнод, Дархан, Орхон, Ховд аймгийн төв, нэг сумыг сонгон судалгаанд хамруулсан. Сонгогдсон өрхөөс боловсролын үйлчилгээний талаар хамгийн их мэдээлэлтэй гишүүн болох эцэг эсвэл эхийг сонгож, судлаач асуултыг нэг бүрчлэн асууж, хариуг тэмдэглэх байдлаар мэдээллийг цуглуулав.

² Түүврийн тархаалттай холбоотойгоор түүврийн хэмжээг 1120 болгож засварлав.

Хүснэгт 3. ТАШН³ болон хамрагдсан оролцогчийн тоо

| Аймаг/дүүрэг | Судалгаанд хамрагдах нэгжийн тоо | Дүнд эзлэх хувь |
|------------------------------|----------------------------------|-----------------|
| Бүгд | 1,120 | 100% |
| Улаанбаатар хот нийт | 560 | 50% |
| Баянгол дүүрэг | 93 | 8% |
| Сүхбаатар дүүрэг | 94 | 8% |
| Сонгинохайрхан дүүрэг | 94 | 8% |
| Хан-Уул | 93 | 8% |
| Чингэлтэй дүүрэг | 93 | 8% |
| Баянзүрх дүүрэг | 93 | 8% |
| Хөдөө нийт | 560 | 50% |
| Баруун бүс | 139 | 12% |
| Ховд аймаг, Жаргалант сум | 100 | 9% |
| Мянгад сум | 42 | 4% |
| Зүүн бүс | 139 | 12% |
| Дорнод аймаг, Хэрлэн сум | 97 | 9% |
| Чойбалсан сум | 42 | 4% |
| Төвийн бүс | 139 | 12% |
| Дархан-Уул аймаг, Дархан сум | 97 | 9% |
| Шарын гол сум | 42 | 4% |
| Хангайн бүс | 140 | 12% |
| Орхон аймаг, Баян-Өндөр сум | 97 | 9% |
| Жаргалант сум | 43 | 4% |

Тоон судалгаанд оролцогчдын мэдээлэл

Судалгаанд нийт 1120 оролцогч хамрагдсанаас 25-35 насны оролцогчид давамгайлжээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 72 хувь нь эмэгтэй байгаа бөгөөд энэ нь өрхийн хувьд хүүхэдтэй холбоотой асуудалд ихэвчлэн гэрийн эзэгтэй нар оролцдог, илүү мэдээлэлтэй болохыг харуулж байна (График 1, 2).

ИИМН
СУДАЛГААНЫ САН

³ Түүврийн Анхан Шатны Нэгж

График 1. Судалгаанд оролцогчид, насны бүлгээр





График 2. Судалгаанд оролцогчид, хүйсээр



Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин харьцангуй өндөр буюу дийлэнх нь дээд боловсролтой, 34 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Мөн 80 гаруй хувь нь идэвхтэй ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс байна (График 4). Судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж орлогын хэмжээг ерөнхийд нь бүлэглэвэл 45 хувь нь 600 мянга хүртэл, 35 хувь нь 600-аас 1 сая хүртэл төгрөгийн өрхийн орлоготой байна (График 5).

График 3. Судалгаанд оролцогчид, боловсролын түвшнээр





График 4. Судалгаанд оролцогчид, ажил эрхлэлтээр




График 5. Судалгаанд оролцогчид, өрхийн орлогын бүлгээр



Судалгаанд хамрагдсан нийт 1120 оролцогчийн 50 хувь буюу 560 оролцогч цэцэрлэгийн, 63 хувь буюу 700 оролцогч дунд сургуулийн, 24 хувь нь буюу 273 оролцогч их дээд сургууль, МСҮТ, коллежид суралцдаг хүүхэдтэй байна. Тодруулбал, 1120 оролцогч боловсролын аль нэг шатлалд суралцдаг 1839 хүүхэдтэй бөгөөд нэг өрхөд дунджаар 2 хүүхэд ногдож байна. Нийт 1839 хүүхдийн 11 хувь нь буюу 203 хүүхэд боловсролын хувийн байгууллагад, 89 хувь нь буюу 1636 хүүхэд боловсролын улсын байгууллагад суралцаж байна (График 6, Хүснэгт 4).

График 6. Судалгаанд оролцогчдын хүүхдүүдийн боловсролын байгууллагын шатлал



Хүснэгт 4. Судалгаанд оролцогчдын хүүхдүүдийн боловсролын байгууллагын шатлал, эзэмшлийн хэлбэрээр

| Боловсролын байгууллагын шатлал | Эзэмшил | Хот | Хөдөө | Нийт | Нийт |
|--|---------|-----|-------|------|------|
| СӨБ | Хувийн | 57 | 26 | 83 | 634 |
| | Улсын | 240 | 311 | 551 | |
| ЕБС | Хувийн | 24 | 23 | 47 | 900 |
| | Улсын | 409 | 444 | 853 | |
| Их, дээд сургууль, МСҮТ, коллеж | Хувийн | 38 | 35 | 73 | 305 |
| | Улсын | 94 | 138 | 232 | |
| Судалгаанд хамрагдсан 1120 өрхөд байгаа боловсролын байгууллагад суралцаж буй хүүхдийн тоо | | | | | 1839 |
| Нэг өрхөд ногдох суралцаж буй хүүхдийн тоо | | | | | 2 |

1.3 Чанарын судалгаа

Тоон судалгааны агуулга чиглэлд багтаагүй асуудлаар экспертийн түвшний дэлгэрэнгүй мэдээлэл олж авах зорилгоор чанарын судалгааг ганцаарчилсан ярилцлагын аргаар явуулсан. Чанарын судалгаанд багш, ажилтнууд, боловсролын төрийн захиргааны байгууллагын, албан хаагч, ТББ, салбарын эрдэмтэн судлаач, оюутан, хувийн хэвшлийн байгууллагын нийт 120 төлөөлөл хамрагдав. Судалгаанд оролцогчдыг боловсролын байгууллагын шатлал, эрхэлж буй ажил, албан тушаалын ангиллаар, байршлыг харгалзан сонгосон. Ингэхдээ шатлал болон засаг захиргааны нэгжийн дагуу байгууллагуудын бүрэн жагсаалтыг гаргасан бөгөөд судалгааны хуваарилалтын дагуу санамсаргүй сонголтын аргаар ганцаарчилсан ярилцлагад хамрагдах байгууллагыг сонгосон. Үүний дараа сонгогдсон байгууллагаас судалгаанд оролцохыг зөвшөөрсөн багш, ажилтныг ганцаарчилсан ярилцлагад урьж оролцуулсан болно.

Сонгогдсон байгууллагын багш, ажилтан хүндэтгэх шалтгааны улмаас судалгаанд хамрагдах боломжгүй, эсвэл татгалзсан тохиолдолд дараагийн байгууллагын оролцогчийг сонгосон. Судалгааны мэдээлэл цуглуулалтын явцад хувь хүний мэдээллийг хамгаалах, хөндлөнгийн нөлөөгүй, үнэн бодит мэдээлэл авах үүднээс тухайн байгууллагыг төлөөлөх оролцогчтой шууд харилцсан бөгөөд оролцогчийн нэр, байгууллагын мэдээллийг аваагүй. Ярилцлагын чиглүүлэх асуултын хүрээнд оролцогчтой харилцан ярилцаж, тодруулах байдлаар мэдээлэл авсан болно. Судалгаа сэдвийн хувьд эмзэг асуудлыг хөндөж байсан тул хариулахаас татгалзах, хангалттай мэдээлэл өгөхгүй байх тохиолдлууд гарч байв. Чанарын судалгаанд Ховд, Дархан, Орхон, Дорнод аймгууд болон Улаанбаатар хотоос нийт 120 оролцогчийг хамрагдснаас 60 хувь нь Улаанбаатар хотын, 40 хувь нь хөдөө орон нутгийн төлөөлөл байлаа (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Чанарын судалгааны түүврийн хуваарилалт

| Д/д | Авах мэдээллийн агуулга | Зорилтот бүлэг | Судалгааны нэгж | Байршил | | Нийт |
|------|---|--|--|---------|-------|------|
| | | | | Хот | Хөдөө | |
| 1 | | Сургуулийн өмнөх боловсролын байгууллага | Цэцэрлэгийн эрхлэгч, Багш г.м | 10 | 10 | 20 |
| 2 | Багшийн ёс зүй, төлбөр, хураамж, хандив, тусламж, сурагч, оюутны үнэлгээ, тэтгэлэг, салбарын хүний нөөц, томилгоо, шагнал, урамшуулал, төсөв санхүү, худалдан авалт | Ерөнхий боловсролын сургууль | Сургуулийн захирал, Сургалтын албаны дарга, Багш г.м | 10 | 10 | 20 |
| 3 | | Дээд болон мэргэжлийн боловсролын байгууллага | Сургуулийн захирал, Сургалтын албаны дарга, Багш г.м | 10 | 10 | 20 |
| 4 | Салбарын хүний нөөц, томилгоо, шагнал, урамшуулал, төсөв санхүү, худалдан авалт | Салбарын төрийн захиргааны байгууллагын төлөөлөл / Боловсролын яам, агентлаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтэс/ | Мэргэжилтэн, газар, хэлтсийн дарга | 10 | 5 | 15 |
| 5 | Салбарын худалдан авалт, тендер | Боловсролын салбарын худалдан авах ажиллагаанд оролцдог аж ахуйн нэгж Ном, сурах бичиг, үдийн цай, дүрэмт хувцас/ | Аж ахуйн нэгжийн захирал, удирдлага | 11 | 4 | 15 |
| 7 | Багшийн ёс зүй, төлбөр, хураамж, хандив, тусламж, сурагч, оюутны үнэлгээ, тэтгэлэг, Салбарын хүний нөөц, томилгоо, шагнал, урамшуулал, төсөв санхүү, худалдан авалт | Салбарын эрдэмтэн судлаач, төрийн бус байгууллагын төлөөлөл /Экспертүүд/ | Судлаач, эрдэмтэд, Ахмад багш ажилтан | 10 | 5 | 15 |
| 8 | Багшийн ёс зүй, албан болон албан бус төлбөр, хандив | Оюутны төлөөлөл | Оюутан | 7 | 8 | 15 |
| Нийт | | | | 68 | 52 | 120 |

Чанарын судалгаанд оролцогчдын мэдээлэл

Судалгаанд оролцогчдын 66.7 хувь нь эмэгтэйчүүд байсан бөгөөд тэдгээрийн 60 хувийг 31-50 настай оролцогчид эзэлж байв. Судалгаанд оролцогчдын 86.7 хувь дээд боловсролтой, 40.8 хувь нь магистр зэрэгтэй оролцогч байна (График 7, 8, 9).

График 7. Судалгаанд оролцогчид, хүйсээр



График 8. Судалгаанд оролцогчид, насны бүлгээр





График 9. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал



БҮЛЭГ 2 БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭН ДЭХ ЁС ЗҮЙ, АВЛИГЫН АСУУДАЛ

Энэ бүлэгт боловсролын салбар дахь ёс зүй, авлигын нөхцөл байдлын талаарх судалгаанд оролцогчдын ойлголт, төсөөлөл, хандлага болон бодит тохиолдлыг судлав. Асуулгад боловсрол олгох үйл ажиллагаа, үйлчилгээнд ажиглагддаг зүй бус, ёс суртахуунгүй үйлдэл, эс үйлдэл, хувийн ашиг хонжоо хайх, давуу байдал олж авах, ажил, албан тушаалын эрх мэдлээ ашиглах хэлбэрүүд ямар хэмжээнд байгааг тодорхойлох асуултууд багтсан.

2.1 Боловсролын үйлчилгээн дэх ёс зүй, авлигын талаарх ойлголт, төсөөлөл

Эцэг эхчүүдийн ойлголт, төсөөллийг тодорхойлох зорилгоор урьдчилан бэлтгэсэн 14 үзүүлэлтийг баллын үнэлгээний аргаар үнэлүүлсэн. СӨБ- д хамаарах 5 үзүүлэлтээс мөнгө, албан тушаал, танил тал ашиглан цэцэрлэгт хүүхэд элсүүлэх, бэлэг сэлт, мөнгө авах явдал хамгийн түгээмэл байна (График 10) ЕБС-ын хувьд мөнгө, албан тушаал, танил тал ашиглан сургуульд оруулах, сурлагын үнэлгээнд нөлөөлөх, тэтгэлэг, тусгай хөтөлбөрт хамруулах асуудал их гэж оролцогчдын 40 гаруй хувь үзжээ. Харин их, дээд сургуулийн хувьд бусад шатлалтай харьцуулахад байдал илүү тааруу гэж оролцогчид үзэж байна (График 11, 12). Аль ч шатлалын хувьд асуудал их гэсэн ойлголт давамгайлж, харин бага, огт байхгүй гэсэн хариулт бага хувийг эзэлж байна.

График 10. СӨБ-ын ёс зүй, авлигын асуудлаарх төсөөлөл




График 11. ЕБС-ийн ёс зүй, авлигын асуудлаарх төсөөлөл




График 12. Их дээд сургууль, МСУТ, коллеж дэх ёс зүй, авлигын асуудлаарх төсөөлөл



Үнэлгээний дүнг 1-5 гэсэн тоон утгаар (1-Огт байхгүй, 2-Бага, 3-Дунд зэрэг, 4-Их, 5-Маш их) нэгтгэн авч үзвэл дундаж буюу 2.65 үнэлгээнээс давсан дараах 6 асуудал байна (График 13).

- 1 Сурагч болон оюутнаас бэлэг сэлт, мөнгө авах.
- 2 Сурагч болон оюутныг шударгаар үнэлэхгүй байх.
- 3 Мөнгө, албан тушаал, танил тал ашиглан сургуульд элсүүлэх, шинээр оруулах. Энэ асуудал СӨБ болон их дээд сургуульд илүү арай илүү байна.
- 4 Мөнгө, албан тушаал, танил тал ашиглан сургууль, анги өөрчлөх. Энэ асуудал их дээд сургуульд хамгийн их байна.
- 5 Мөнгө, албан тушаал, танил тал ашиглан сургалтын үнэлгээнд нөлөөлөх.
- 6 Мөнгө, албан тушаал, танил тал ашиглан тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах.

График 13. Ёс зүй, авлигын асуудлын үнэлгээ тоон утгаар, шатлалаар



Боловсролын салбар дахь ёс зүй, авлигын нөхцөл байдлыг чанарын судалгааны оролцогчдоор мөн адил баллын аргаар үнэлүүлсэн. Багш, ажилтан, эксперт судлаачдын үзэж байгаагаар боловсролын салбарт ёс зүй, авлигын асуудал 3.37 буюу дундаас дээш түвшинд байна. Үнэлгээг боловсролын шатлал, байгууллагаар ангилж үзвэл СӨБ, ЕБС, их дээд сургууль болон аймаг дүүрэгтэй харьцуулахад салбарын яам, агентлагт авлига их гэсэн үнэлгээ өгчээ. Эцэг эхчүүдийн үнэлгээтэй харьцуулахад багш, ажилчид салбарын нөхцөл байдалд илүү шүүмжлэлтэй хандаж байна.

График 14. Боловсролын салбар дахь ёс зүй, авлигын нөхцөл байдлын ерөнхий үнэлгээ



Боловсролын үйлчилгээнд авлигын асуудал нийтлэг байгаа ч цаашид ийм хандлага үргэлжлэхийг оролцогчдын 90 гаруй хувь нь буруу гэж үзэж байна (График 15). Харин өрхийн орлого өндөртэй болон цэцэрлэгийн хүүхэдтэй эцэг эхчүүд үүнийг зөв гэж үзэх хандлагатай нь ажиглагдлаа. Буруу гэж үзэж байгаа хэдий ч эцэг эхчүүдийн 68 хувь нь бэлэг сэлт, мөнгө өгдөг байдал цаашид хэвээр байна, эсвэл нэмэгдэнэ гэсэн гутранги төсөөлөлтэй байна (График 16).

График 15. Багш, ажилтанд бэлэг сэлт, мөнгө өгдөг одоогийн энэ хандлага цаашид байх нь зөв эсэх





График 16. Багш, ажилтанд бэлэг сэлт, мөнгө өгдөг одоогийн энэ хандлага цаашид нэмэгдэх эсэх



Багш, ажилтанд бэлэг сэлт, мөнгө өгөх, эсвэл сургууль, цэцэрлэгт хандив өгөх нь хүүхдэд давуу тал бий болгохгүй гэж эцэг эхчүүдийн дийлэнх буюу 56 хувь нь үзэж байна. Гэхдээ 18-25 насны эцэг, эхчүүдийн 54 хувь нь эдгээр нь хүүхдэд давуу байдал олгоно гэж үзжээ (График 17). Харин “бэлэг сэлт, мөнгө, хандив өгөхгүй байх нь хүүхдэд сул тал үүсгэх үү?” гэсэн асуултад “тийм” хариулт 10 орчим хувиар, мөн “мэдэхгүй” хариулт цөөн хувиар нэмэгдсэн нь өгөхгүй байх нь зарим тохиолдолд асуудал үүсгэдэг байж болохыг харуулж байна (График 18). Энэ хандлага цэцэрлэгийн хүүхэдтэй эцэг эхчүүд, ялангуяа залуу эцэг эхчүүдэд илүү давамгайлж байна.

График 17. Багш, ажилтанд бэлэг сэлт, мөнгө өгөх, эсвэл сургууль, цэцэрлэгт хандив өгөх нь хүүхдэд давуу тал олгодог эсэх






График 18. Багш, ажилтанд бэлэг сэлт, мөнгө өгөхгүй, эсвэл сургууль, цэцэрлэгт хандив өгөхгүй байх тохиолдолд хүүхдэд сул тал үүсдэг эсэх



2.2 Боловсролын үйлчилгээн дэх авлигын тохиолдол

Боловсролын үйлчилгээн дэх ёс зүй, авлигын нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор сүүлийн 1 жилийн хугацаанд эцэг эхчүүдээс боловсролын байгууллагын ажилтан, албан хаагчид бэлэг сэлт, мөнгө өгсөн, үйлчилгээ үзүүлсэн тохиолдлуудыг судлав. Харин бэлэг сэлт, мөнгө өгөх болсон зорилго, хэмжээ, арга хэлбэр зэрэг нарийвчилсан үзүүлэлтүүдийг тодорхойлохдоо хамгийн сүүлийн тохиолдлын мэдээллийг ашигласан болно. Тоон судалгаанд оролцогчдын 444 нь буюу 40 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд боловсролын байгууллагын ажилтан, албан хаагчид хувьд нь бэлэг сэлт эсвэл мөнгө өгчээ (График 19). Харин чанарын судалгаанд оролцогчид боловсролын салбарын аль ч шатанд авлига, ашиг сонирхлын зөрчил байгааг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд тэдний 85 хувь нь боловсролын үйлчилгээнд авлига, ашиг сонирхлын зөрчил ажиглагддаг гэжээ. Түүнчлэн сүүлийн нэг жилийн хугацаанд ийм тохиолдол байсан эсэхийг асуухад оролцогчдын 68.3 хувь буюу 82 оролцогч өөрт болон ойр дотны хүмүүст тохиолдсон ямар нэг бодит жишээг нэрлэжээ.

График 19. Сүүлийн 1 жилийн хугацаанд бэлэг сэлт, мөнгө өгсөн тохиолдол



СӨБ-ын шатанд хамгийн нийтлэг асуудал нь хүүхэд цэцэрлэгт оруулахтай холбоотойгоор цэцэрлэгийн багш, удирдлагад бэлэг сэлт, мөнгө өгөх, танил талаа ашиглах явдал бөгөөд цэцэрлэгийн хүртээмж хангалтгүй байгаа нь суурь шалтгаан болж байна. ЕБС-ын шатанд хүүхдийг өөр анги эсвэл сургуульд шилжүүлэхэд тохиолдож буй авлигын асуудал хамгийн их байна. Тухайлбал, сургалт сайн, эсвэл тусгай сургалттай гэгдэх цөөн тооны сургуулиудад хүүхэд оруулах, хөдөөнөөс хот, хотын захын сургуулиас төвийн сургуульд шилжүүлэхэд, мөн сурагчдын сургалт, шалгалтын үнэлгээнд нөлөөлөхөд хээл хахууль өгдөг, албан тушаал ашигладаг асуудал яригдаж байна. Тусгай сургалттай сургууль, анги нээх зэрэг нь үүний нэг шалтгаан бөгөөд боловсролын салбарт тэгш бус байдлыг бий болгох сөрөг талтай болохыг боловсролын байгууллагын ажилтнууд дурджээ. Харин их, дээд сургуулийн хувьд оюутан шинээр элсэн орох болон шилжин суралцах, анги солиулах, сургалтын дүн, үнэлгээтэй холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчлүүд нийтлэг асуудал болсон байна.


Ярилцлагаас:

Шат шатандаа л ёс зүйн асуудал нь өөр өөр хэлбэртэй илэрдэг. Жишээ нь ЕБС-н хувьд цалин хөлс багатай, хууль бус янз бүрийн мөнгө татаж авдаг, тэгээд эцэг эхүүд нь хэл ам гаргая гэхээр хүүхэдтэй нь хандах хандлага өөрчлөгдчих болов уу гэсэн, хэлж чадахгүй бугшмал асуудал. Манай сургууль дээр ёс зүйн хороо анх байгуулагдаад 10 жил болж байна. Багш нарын ёс зүйн зөвлөл гэдэг дээр нэг ч гомдол орж ирээгүй. Асуудалгүй болоод цэвэрхэн байгаа юм уу гэхээр үгүй.

Багш, ажилтны төлөөлөл

Тоон судалгааны дүнгээс боловсролын шатлалаар харвал эцэг, эхчүүдийн 46 орчим хувь цэцэрлэгийн хүүхэдтэй холбоотойгоор, 40 хувь ЕБС-ийн хүүхэдтэй холбоотойгоор, 30 хувь нь их дээд сургуулийн оюутантай холбоотойгоор бэлэг сэлт, мөнгө өгсөн байна (График 20).

График 20. Сүүлийн нэг жилийн хугацаанд бэлэг сэлт, мөнгө өгсөн тохиолдол, шатлалаар



Ярилцлагаас:

Өнгөрсөн жилийн 9 сарын нэгэнд сумаас шилжиж ирсэн ахын хүүхдийг ЕБС-д оруулахын тулд багшаар дамжуулан 300 мян.төгрөг өгсөн. Багшаар дамжуулсан шалтгаан нь тухайн салбарт ажиллаж байгаа таньж мэддэг хүн гэдэг утгаараа харьцангуй бага үнэ ханштай. Хэрвээ шууд удирдлагад нь хүсэлт гаргавал хандив нэрийн доор 500 мянган төгрөгний ханштай байсан.

Багш, ажилтны төлөөлөл

Харин нэг жилийн хугацаанд бэлэг сэлт, мөнгө өгсөн гэх оролцогчдын ойролцоогоор 70 гаруй хувь нь 1-2 удаа, 23 хувь нь 3-4 удаа бэлэг сэлт, мөнгө өгөх тохиолдол гарчээ. Энэ давтамж боловсролын байгууллагуудад ойролцоо байна (График 21). Эдгээр тохиолдлыг илүү нарийвчлан үзвэл аль ч шатлалд сургууль, цэцэрлэгт анх орох болон төгсөх жилүүдэд бэлэг сэлт, мөнгө өгөх шаардлага үүсдэг болох нь харагдаж байна (График 22).

График 21. Бэлэг сэлт, мөнгө өгсөн давтамж, шатлалаар




Ярилцлагаас:

...2010-2012 онд 3 жил дараалаад цэцэрлэгүүд дээр судалгаа авч үзэхэд амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур ядуу, нэн ядуу орлоготой айл өрхийн хүүхдүүдийн эзлэх хувь нь 19%-иар буураад, дунд болон дундаас дээш орлоготой өрхийн хүүхдийн эзлэх хувь 25%-иар нэмэгдчихсэн байсан. Хүн болгон хүүхдээ улсын цэцэрлэгт оруулчих гэсэн хандлага гарч ирээд цэцэрлэг хүрэлцэхгүй учраас очир дараалал гардаг, энэнээс улбаалаад хахууль өгдөг, хахууль нь хандив хэлбэрээр ч байж болно, эсвэл танил талаараа. Тэгэнгүүт мэдээж орлого багатай хүмүүс нь хахууль, хандивыг нь өгч чадахгүй, танил тал тэд нарт бараг байхгүй. Тэгэхээр тэр хүмүүс шахагдаад ийм юм болж байгаа юм.

Эрдэмтэн, судлаачдын төлөөлөл

График 22. Бэлэг сэлт, мөнгө өгч, үйлчилгээ үзүүлсэн байдал, анги курсээр



Бэлэг сэлт, мөнгө өгсөн тохиолдол бүр тодорхой шалтгаан, сэдэлтэй байна. Жишээ нь СӨБ-ын хувьд багшийн хандлагыг өөрчлөх, цэцэрлэгт шинээр оруулах асуудал, харин ЕБС, их дээд сургуулийн хувьд анги, сургууль төгсгөсөнд талархал илэрхийлэх асуудал хамгийн гол шалтгаанд багтжээ (График 23). Түүнчлэн хүүхэддээ хандах хандлагыг сайжруулах, эсвэл ялгаварлан гадуурхуулахгүй байх зорилгоор багш нарт мөнгө, бэлт сэлт өгөх тохиолдол нийтлэг байна. Тухайлбал, хотын төвийн цэцэрлэгийн багш, туслах багшийн хамт 40-50 хүүхэдтэй ажилладаг бөгөөд багш хүүхэд нэг бүртэй ажиллах, зохих анхаарал тавих боломжийг бууруулдаг. Энэ нь үйлчилгээ, ёс зүй, харилцааны асуудал үүсгэж, улмаар бэлэг сэлт, мөнгө өгөх замаар нөхцөл байдалд нөлөөлөхийг эцэг эхчүүд оролддог байна. Их, дээд сургуулийн хувьд оюутны үнэлгээг гаргах, дүн тавихад хамгийн шударга бус байдаг гэж чанарын судалгаанд оролцсон оюутнууд үзэж байна. Үүнд шалгалтын дүнг өөрчлөх, дипломын голч дүнг нэмэгдүүлэх, хичээлд бүрэн суухгүйгээр диплом авах зэрэг багтаж байна.

График 23. Бэлэг сэлт, мөнгө өгсөн шалтгаан, шатлалаар



Ярилцлагаас:

Жилийн өмнө нэг хүн Орчлон сургуульд явж байсан хүүхдээ гаргаад, 23-р сургуульд оруулах гэсэн байгаа юм. Тэгээд “Х” гэх хүн хүүхдийг нь оруулж өгнө гээд 2.5 сая төгрөг авсан. Тэр “Х” гэгч 5-6 хүүхдийг 23, 84 зэрэг янз бүрийн сургуульд оруулна гээд 5-6 эцэг, эхээс тус бүр 2.5 сая төгрөгийг авсан байсан. Тэгээд авсан мөнгийг 23-р сургуулийн багш “А”-д өгсөн, “А” нь бас цаашаа өгсөн гээд бүр сүлжээ болоод явж өгсөн байх жишээний. Үр дүнд нь “Х” шүүх, цагдаад баригдаад ял аваад явсан л даа, гэвч өршөөлөөр суллагдчихсан гэсэн. Ер нь дүүрэг бүрийн тусгай сургалттай, чанартай гэж нэрлэгддэг 1, Орос 3, 18, 23 гээд нилээдгүй сургуулиуд өөрсдийн ханштай гэж яригддаг.

Багш, ажилтны төлөөлөл

Бэлэг сэлт, мөнгийг хүлээн авагчийн хувьд багш нар хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд удирдах албан тушаалтны эзлэх хувь бага байна. Бүх шатлалд бэлэг сэлт, мөнгө нийтлэг хэлбэр байгаа бөгөөд СӨБ, ЕБС-ын хувьд бэлэг сэлт арай илүү байхад, их дээд сургуульд бэлэн мөнгө давамгай байна (График 24, 25). Хүлээн авсан хүнээр нь ангилж харвал албан тушаал ахих тусам бэлэг сэлт бус бэлэн мөнгө өгөх хандлагатай байна. Тодруулбал багш нар авсан тохиолдолд 60 орчим хувь нь бэлэг сэлт байгаа бол удирдах албан тушаалтнууд ихэнх тохиолдолд бэлэн мөнгө авдаг байна (График 26).

График 24. Бэлэг сэлт, мөнгө авсан хүн, шатлалаар



Ярилцлагаас:

Манай сургуулийн нэг багш ангийн хүүхдээс 100.0 мян.төгрөг авч дадлагын дүнг нь тавьж байсан. Ерөөсөө дадлага хийж байгаагүй гэдгийг нь ангийнхан бүгд мэдэж байхад дүнг нь гаргачихаад ангийнхаа нэг хүүхдийг улираамаар байна уу гэж бид нарыг загнаж байсан. Багш нар оюутнуудаас мөнгө авах үзэгдэл зөндөө байдаг.

Оюутны төлөөлөл

График 25. Бэлэг сэлт, мөнгө, үйлчилгээний эзлэх хувь, шатлалтаар




График 26. Бэлэг сэлт, мөнгө өгсөн хүн, өгсөн зүйлээр



Үзүүлэлтээс харахад дийлэнх тохиолдолд бэлэг сэлт, мөнгө өгөх санаачлагыг эцэг эхчүүд өөрсдөө гаргадаг байна. Харин шалтгааны хувьд ямар нэг асуудал шийдвэрлэх зорилгоор өгөх хандлага СӨБ болон ЕБС-д илүү өндөр байгаа бол их, дээд сургууль, МСҮТ, коллежид багш санаачлага гаргах хандлага илүү өндөр байна (График 27). Мөн тухайн бэлэг сэлт, мөнгө ихэнх тохиолдолд эцэг эхчүүдээс шууд багш, ажилтанд очдог байна. Банкны дансаар шилжүүлэх, танилаараа дамжуулах цөөн тохиолдлууд байгаа бол хүүхдээрээ дамжуулж өгөх тохиолдол их дээд сургуульд илүү өндөр байна (График 28).

График 27. Бэлэг сэлт, мөнгийг санаачлагч



Ярилцлагаас:

Би өөрөө 23-р сургуульд ачийгаа өгөх гээд чадахгүй байна. Гэхдээ харъяаллын бус л даа. Миний гуйж байгаа хүн цаадуул чинь юм хараад байгаа бололтой хөдлөхгүй байна яанаа л гээд байгаа. Жишгээр 5 саяыг өгдөг гэсэн мэдээлэл ирчээд л байж байна даа... 8 сард эргээд ярина л гэсэн. 1-р 10 жил бол шууд авдаг гэсэн 5, 10 гээд л. Том бизнесмэнүүд чинь өгөөд, оруулаад сургачихсан байна. Өөрөө юмаа хөөцөлдөж байгаа хүмүүст бас буруу байна.


Эрдэмтэн, судлаачдын төлөөлөл

График 28. Бэлэг сэлт, мөнгө өгсөн арга зам, шатлалаар



Бэлэг сэлт, мөнгө өгсөний дараахь үр дүн зорилгоос хамаарч өөр өөр байна. Тухайлбал, сургалтын үнэлгээ болон шалгалтын дүн ахиулах, анги сургууль шилжүүлэх зорилгоор бэлэг, сэлт мөнгө өгсөнөөр хүссэн үр дүндээ хүрэх нь илүү байдаг бол тэтгэлэгт хамруулах, багш, удирдлагын хандлагыг өөрчлөх зорилгоор өгсөн бэлэг сэлт, мөнгөний үр дүн бага байна (График 29). Үүнд шалгалтын дүнг өөрчлөх, дипломын голч дүнг нэмэгдүүлэх, хичээлд бүрэн суухгүйгээр диплом авах зэрэг зүй бус үйлдлүүд багтаж байна. Элсэлт, шалгалт цахим хэлбэрт шилжиж зарим зүй бус асуудлыг хязгаарлаж байгаа гэх боловч эдгээр үйлдлүүд ихэвчлэн багш, оюутны хооронд шууд явагддаг нь асуудал нууц далд, мэдэгдэхгүй байх боломжийг олгодог байна. Байгууллагын шатлалаар нь үзвэл СӨБ болон их, дээд сургууль, МСҮТ, коллежид суралцдаг хүүхэдтэй эцэг эхчүүд хүссэн зүйлээ биелүүлсэн байна. ЕБС-д суралцдаг хүүхэдтэй эцэг эхчүүд ямар нэг үр дүн хүлээлгүйгээр багш, удирдлагад бэлэг сэлт, бэлэн мөнгө өгсөн байдал өндөр хувьтай байна (График 30).

График 29. Бэлэг сэлт өгсний үр дүн, шатлалаар



Ярилцлагаас:

Бодитой жишээ хэлье. Нэг хувийн дээд сургуулийн оюутнууд шалгалтаа өгөх гээд өөрсдөө багш нартайгаа ярьж шалгалтаа өгдөг сонин системтэй газар. Хуучнаар бол ангиараа шалгалтаа өгөөд явдаг байлаа. Одоо бол хүүхдүүд багш нартайгаа ярьж байгаад цагаа тохироод шалгалтаа өгдөг болж. Шалгалтаа өгье гэж багшруугаа ярихлээр өөдөөс нь дансныхаа дугаарыг явуулсан. Мөнгө өгвөл дүн авна, өгөхгүй бол авахгүй.

Эрдэмтэн судлаачдын төлөөлөл

График 30. Бэлэг сэлт, мөнгө өгснөөр хүрсэн үр дүн, зорилгоор



Ярилцлагаас:

Их сургуульд бол төгсөхөд, дүн аргалахад өгдөг. Дипломын хамгаалалтанд нарийн бичгүүд бичнэ ш дээ, тэд нарт бол өгдөг, бөөнөөрөө. 3, 4-үүлээ нийлээд нарийн бичигт юм өгчихөөр гайгүй, дүнг нь янзлах тийм юм байдаг юм шиг байна лээ. Их сургуульд бол багш нар байна. Дандаа багш нараас дүн гуйж явдаг. Жишээлбэл тэрийг 70 тавиад өгөөч, 50 тавиагч өгөөд гээд гуйхаар багш хүн гуйж байгаа юм чинь гээд тэр багш хүүхдүүдээс мөнгө авч хүүхдүүдийн дүнг тавьдаг. Тийм муухай системтэй.

Багш, ажилтны төлөөлөл

Эцэг эхчүүдийн өгсөн бэлэг сэлтийн өртөг, мөнгөний дүн оролцогчдын ихэнхи буюу 67 хувьд нь 60 хүртэлх мянган төгрөг байна. Боловсролын шатлалаар үзвэл их, дээд сургууль болон МСҮТ, коллежид суралцаж буй хүүхэдтэй холбоотой гарсан зардал хамгийн өндөр байна. Мөн хөдөө, орон нутгийн иргэдийн хувьд оюутантай холбоотой гарсан зардал нь хамгийн өндөр байгаа бол хотод цэцэрлэгийн хүүхэдтэй холбоотой гарсан зардал өндөр байна. Тухайлбал, хөдөөгийн өрх их, дээд сургуульд хүүхэд шинээр оруулахад дунджаар 1.2 сая төгрөгтэй тэнцэх бэлэг сэлт, мөнгө өгсөн байна. Харин анги солиход хөдөөгийн өрх дунджаар 835 мянган төгрөг, хотын өрх дунджаар 575 төгрөг зарцуулжээ (График 31, 32).

График 31. Бэлэг сэлт, мөнгөний хэмжээ, хувиар





График 32. Бэлэг сэлт, мөнгөний хэмжээ, хот хөдөөгийн дундаж



Хүснэгт 6. Бэлэг сэлт, мөнгөний хэмжээ, анги, хот, курсээр

| Шатлал | Улсын хэмжээнд | Хот | Хөдөө |
|------------------------------------|--------------------------|-------|-------|
| СӨБ | Ясли /2 нас хүртэлх/ | 145.0 | 120.8 |
| | Бага анги /2 нас/ | 177.5 | 163.5 |
| | Дунд анги /3 нас/ | 150.8 | 143.8 |
| | Ахлах анги /4 нас/ | 68.7 | 57.9 |
| | Бэлтгэл анги /5 нас/ | 130.9 | 49.7 |
| ЕБС | Бага анги /1-5р анги/ | 70.8 | 52.4 |
| | Дунд анги /6-9р анги/ | 84.1 | 60.8 |
| | Ахлах анги /10-12р анги/ | 80.2 | 69.0 |
| Их, дээд сургууль, МСҮТ, коллеж | I курс | 613.6 | 816.3 |
| | II курс | 178.1 | 77.5 |
| | III курс | 43.3 | 34.5 |
| | IV курс | 47.1 | 28.8 |
| | V курс | 50.0 | 50.0 |

Ярилцлагаас:

Хүүхдээ харъяалалтай цэцэрлэгт 350.0 мян.төг өгч оруулсан. Энэ жил бас давтагдана. Яагаад гэвэл өдөр нь ажилтай хонож оочирлоод зогсох боломжгүй. Дүүг нь энэ жил бас л дээрх ханшаар хандив нэрээр цэцэрлэгт оруулна. Хотод гэрт ойрхон цэцэрлэгт хүүхэд 40-50 мян.төг-өөр тоглоом авч өгч оруулсан. Тэр нь 18 хүүхэдтэй байх ёстой, гэтэл 25-26 хүүхэдтэй. Би 7 хоног гуйж байж оруулсан.

Багш, ажилтны төлөөлөл

Ярилцлагаас:

Сургуулийн сургалтын албаны нэг ажилтанд 3 сая төгрөг өгчихвөл албан ёсны дипломыг үлдсэн хичээллүүддээ суулгүйгээр дипломыг нь төгсөх оюутнуудтай хамт гаргаж өгнө гэж байсан. Манай ангийн 2 хүүхэд дипломоо авсан. Сүүлийн нэг жилдээ огт суугаагүй. Улсын тэтгэлэгт 2-3 мянган доллар өгөөд явдаг тухай яриа сонссон.

Оюутны төлөөлөл

График 33. Бэлэг сэлт, мөнгөний хэмжээ, өгсөн зорилгоор



Ярилцлагаас:

Дүнгийн хувьд ил тод байх хэрэгтэй. Одоогийн ЕБС-ийн сурагчид болон оюутнууд бие биенийхээ дүнг мэдэхээ больсон байна. Энэ нь дүн засах асуудлаар авилга, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил гарсан эсэхийг хянах боломжгүй болж байна. Энэ тал дээр асуудалтай байна гэж хардаж байна. Жишээ нь оюутан муу сурдаг мөртлөө авилга өгөөд онц дүн авсан байж болох юм. Энэ тохиолдолд дүнг шифрээр харуулдаг учир олон нийт хяналт тавих нь хязгаарлагдмал болж байна.

Багш, ажилтны төлөөлөл

Зарцуулсан мөнгөний хэмжээ 40.0 мянгаас доош үед өрхийн төсөвт үзүүлэх сөрөг нөлөө нь харьцангуй бага байна. Харин энэ дүн 60-100 мянган төгрөг хүрэхэд мэдэгдэхүйц нөлөөлж байгаа бол, 200 мянгаас дээш болоход төсөв санхүүгийн хүндрэл учруулж эхэлж байна (График 34). Мөн өрхийн орлого нэмэгдэхэд бэлэг сэлт, мөнгө өгсөн хувь болон зарцуулалтын хэмжээ нь өсч байна.

График 34. Бэлэг сэлт, зарцуулсан мөнгө өрхийн төсөвт нөлөөлсөн байдал

**Ярилцлагаас:**

Тэгэхээр энэ чинь тухайн тэр мөнгө өгөөд ч юм уу, ямар нэг юм өгөөд дүнгээ гаргуулж байгаа хүн тэр дүнг нь гаргаж өгч байгаа багш хоёрын хооронд бол асуудал үүсэхгүй юм шиг харагдаж байгаа мөртлөө яг өөрийнхөө чадлаар сураад явж байгаа оюутнуудад аягүй сөрөг нөлөө үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, нийгэмд, тэр ангид сурч байгаа оюутнуудын дунд үнэн шударгаар явахад болдоггүй юм байна гэдэг ойлголт суучихаар, нийгэм дээр гараад ажил хөдөлмөр эрхлээд ирэхээрээ яг л тэр хандлагаараа л явдаг.

Эрдэмтэн судлаачдын төлөөлөл

2.3 Боловсролын үйлчилгээн дэх хандив тусламж, төлбөр хураамжийн талаарх ойлголт, төсөөлөл

Энэ бүлэгт боловсролын үйлчилгээн дэх хандив тусламж, төлбөр хураамжийн талаарх судалгаанд оролцогчдын ойлголт, төсөөлөл болон тохиолдлыг судалсан үр дүнг нэгтгэв. Хандив тусламж, төлбөр хураамж гэдэгт хүүхдийн суралцах үйл явц, сургалтын хэвийн орчин нөхцөлд зориулж эцэг эхчүүдээс боловсролын байгууллагад өгсөн эд зүйлс, хөрөнгө, мөнгийг ойлгож судалгааг явуулав. Хандив тусламж, төлбөр хураамж авах явдал СӨБ, ЕБС-ын хувьд нийтлэг гэж судалгаанд оролцогчид үзэж байна. Ялангуяа, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд зориулж эд зүйлс, бэлэн мөнгө авах, ном, гарын авлага, үзвэр үйлчилгээний билет санал болгох, худалдах явдал их байна (График 35, 36). Хандиваар оруулах тохиолдолд зарцуулалт, тайлагнал тодорхойгүй, мэдээлэл өгдөггүй учраас хандив нэрээр авлига авдаг гэх хардлага байна.

График 35. СӨБ-ын шатанд дахь хандив тусламж, төлбөр хураамжийн талаарх төсөөлөл




График 36. ЕБС-ийн шатны хандив тусламж, төлбөр хураамжийн талаарх төсөөлөл



Харин их, дээд сургууль, коллежийн оюутнуудад давтлага өгөх, ном, гарын авлага, үзвэр үйлчилгээний билет санал болгох, худалдах явдал их гэсэн ойлголттой байна (График 37). Их, дээд сургуулиудын хувьд багш нар оюутны хөдөлмөрийг ашиглах явдал харьцангуй түгээмэл байдаг байна. Тухайлбал, хэвлүүлсэн ном, гарын авлага худалдах, судалгааны ажил хийлгэж, үүний хариуд шалгалтын оноог нэмэгдүүлдэг байна. Мөн сургуулийн захиргаанаас янз бүрийн тоглолт, нийтийн арга хэмжээний тасалбар худалдах явдал түгээмэл байна.

График 37. Их, дээд сургууль, коллежийн шатны хандив тусламж, төлбөр хураамжийн талаарх төсөөлөл



Дээрх 3 шатлалын үнэлгээний дүнг 1-5 гэсэн тоон утгаар (1-Огт байхгүй, 2-Бага, 3-Дунд зэрэг, 4-Их, 5-Маш их) нэгтгэн авч үзвэл дийлэнх үзүүлэлтүүд 3 буюу дунд зэрэг хэмжээтэй байна гэсэн үр дүнг харуулж байна (График 38).

График 38. Хандив тусламж болон төлбөр хураамжтай холбоотой үзүүлэлтүүдийн үнэлгээ




Судалгаанд оролцогчдын ойлголтоор хандив, тусламж, төлбөр хураамжийн зарцуулалт, тайлагнал, үр дүн хангалтгүй, ил тод нээлттэй бус байна. Тодруулбал, оролцогчдын ердөө 20 хувь зарцуулалт, тайлагнал ил тод гэж үзсэн бол 37 хувь нь огт чадахгүй байна гэж үзжээ (График 39). Мөн сургалтын байгууллагад нэмэлт төлбөр, хандив өгөхийг оролцогчдын дийлэнх нь буюу 83 хувь нь буруу гэж үзжээ (График 40).

График 39. Хандив, тусламж, төлбөр хураамжийн зарцуулалт, үр дүн ил тод, нээлттэй байдаг эсэх



График 40. Сургалтын байгууллагад нэмэлт төлбөр, хандив өгөх нь зөв эсэх



2.4 Боловсролын үйлчилгээн дэх хандив тусламж, төлбөр хураамжийн тохиолдол

Хандив тусламж, төлбөр хураамжийн бодит нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор өнгөрсөн нэг жилийн хугацаанд эцэг эхчүүдээс боловсролын байгууллагад өгсөн хандив тусламж, төлбөр хураамжийн тохиолдлуудыг судлав. Тэдгээрийн тоо хэмжээ, зориулалт, хэлбэр зэрэг нарийвчилсан үзүүлэлтүүдийг хамгийн сүүлийн тохиолдлын мэдээллийг ашиглан тодорхойлсон болно. Түүнчлэн чанарын судалгааны ярилцлагын мэдээлэл, үр дүнг ашиглав. Нийт судалгаанд оролцогчдын 633 буюу 56.5 хувь нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд сургууль, цэцэрлэгт хандив тусламж өгсөн байна (График 41). Шатлалаар үзвэл цэцэрлэгийн хүүхэдтэй эцэг эхчүүдийн 60.7 хувь, ЕБС-д суралцдаг хүүхэдтэй эцэг эхийн 61.4 хувь, их дээд сургуульд суралцдаг хүүхэдтэй эцэг эхийн 46.5 хувь нь сургууль, цэцэрлэгт хандив тусламж өгчээ. Хандив тусламж өгөх явдал цэцэрлэг, сургуулийн түвшинд илүү байна (График 42).

График 41. Сүүлийн 1 жилийн хугацаанд сургууль, цэцэрлэгт хандив тусламж өгсөн эсэх





График 42. Сүүлийн нэг жилийн хугацаанд хандив, тусламж өгсөн байдал, шатлалаар



Ярилцлагаас:

Анги танхим, хүүхдийн суралцах орчинд зориулж мөнгө авч байгааг бол дэмжинэ. Энхийг авлига гэж үзэх нь буруу. Бидний хувьд эцэг эхчүүдээс мөнгө авах тохиолдол байдаг. Тэр нь эргээд суралцах орчинд л зарцуулагддаг. Засварт зориулж 10000₮, цэцгийн сав авахад зориулж 1000₮ авч байсан. Зөвхөн багш нарыг буруутгаж болохгүй. Надад тохиолдсон нэг жишээ байна. Ангийн засварт зориулаад эцэг эхчүүдээс 5000₮ авсан юм. Тэгсэн эцэг эх нь 1111-д хүүхдээс 15000₮ авна гэсэн гэж мэдээлэл өгсөн байсан. Хүүхэд эцэг эхдээ мөнгө нэмж хэлээд багш нар дээр бүх буруу нь ирдэг. Энэ жил дээд тал нь 10000₮ авч болно гэж яам, тамгын газраас шийвэр гарсан. Тэгээд авахаар багш буруутан болдог.

Багш, ажилтны төлөөлөл

Нэг жилийн хугацаанд оролцогчдын дунджаар 80 орчим хувь нь 1-2 удаа, 15,5 хувь нь 3-4 удаа хандив тусламж өгчээ. Энэ давтамж боловсролын байгууллагуудад ойролцоо байна (График 43). Харин оролцогчдын ихэнхи нь сургууль, цэцэрлэгт хандив, тусламж өгсөн байх бөгөөд хандив авах хамгийн гол шалтгаан нь анги танхимын засвар, тохижилт байсан байна (График 44, 45). Аль ч шатлалын хувьд хандив тусламжийн 90 гаруй хувийг бэлэн мөнгө эзэлж байна. Хандив тусламжийг эцэг эхчүүд өөрсдийн санаачлагаар өгөх нь харьцангуй бага, харин эцэг эхийн зөвлөл, багш, сургууль, цэцэрлэгийн удирдлагын санаачлагаар өгөх нь их байна (График 46,47).

График 43. Хандив тусламж өгсөн давтамж, шатлалаар




График 44. Хамгийн сүүлд хандив, тусламж өгсөн байдал, анги курсээр




График 45. Хандив, тусламжийн зориулалт, шатлалаар



Ярилцлагаас:

Эцэг эхийн зөвлөлөөс хүүхдүүдийг амьжиргааны түвшингээр нь бүлэг болгон ангилсан байсан. Тэр ангилалынхаа дагуу өөр өөр мөнгө авдаг. Цахим хичээлд зориулж ангидаа зурагт авахад зориулж 70.0 мян.төг өгсөн. Анги засвар, мандат, баяр ёслолын мөнгө авдаг. Эцэг эхийн зөвлөлөөс шаардсан мөнгийг цаг тухайд нь өгдөг. Ер нь тодорхой давтамжтай мөнгө авдаг. Хүүхдүүд нэг нэгнээ дуурайгаад багшдаа бэлэг өгдөг. Хүүхэд 5-р анги төгсөхөд багш нь бэлгээ захиалсан байсан.

Багш, ажилтны төлөөлөл

График 46. Хандив, тусламжийн хэлбэр, шатлалаар





График 47. Хандив, тусламжийг санаачлагч




Эцэг эхчүүд хандив тусламжийг ихэнх тохиолдолд талархах, туслах зорилготой өгдөг боловч зарим тохиолдолд өөр хүлээлт, эсвэл зорилготой байдаг байна. Тодруулбал, багш, удирдлагын хандлагыг өөрчлөх, сургууль анги шилжүүлэх, дүн үнэлгээ ахиулахын тулд хандив, тусламж өгдөг байна. Ойролцоогоор эцэг эхчүүдийн тал хувь нь ямар нэг үр дүн хүлээгээгүй бол, 20 орчим хувь нь хүссэн үр дүндээ хүрчээ (График 48, 49).

График 48. Хандив тусламж өгсөн зорилго, шатлалаар



График 49. Хандив тусламж өгснөөр гарсан үр дүн



Хандив, тусламжийг хүлээн авагч нь байгууллагын төсөв санхүүг хариуцсан ажилтан бус харин ихэнх тохиолдолд багш нар байгаа нь анхаарал татаж байна. Харин их, дээд сургууль болон МСҮТ, коллежид сургалтын алба, бусад албан тушаалтан хандив, тусламжийг хүлээн авах нь арай илүү байна. Түүнчлэн хандив тусламжийн мөнгө ихэвчлэн бэлнээр багш эсвэл сурагч, оюутны гар дамждаг байна (График 50, 51).

График 50. Хандив тусламжийг хүлээн авсан хүн




График 51. Хандив, тусламж өгсөн арга зам, шатлалаар



Ярилцлагаас:

Авлигыг боловсоноор хандив гэж нэрлээд цэцэрлэг болон 1-р ангийн хүүхдүүдээс авч байгаа нь буруу юм. Энэ хандив гэж нэрлэгдээд байгаа авлигыг боловсролын салбарын хүмүүс хүлээн зөвшөөрөөд авлига гэж үзэхгүй болсон байна.

Багш ажилтны төлөөлөл

Хандив тусламжид зарцуулсан мөнгөн дүнг авч үзвэл нийт 633 тохиолдлын тал хувь нь 20 мянга хүртэл, 30 орчим хувь нь 20-60 мянган төгрөг зарцуулсан байна. Харин 100 мянгаас дээш төгрөгийн хандив бага хувийг эзэлж байна. Энэ дүнг хот, хөдөөгөөр ялган харвал хөдөөгийн эцэг эхчүүд арай илүү хэмжээний мөнгийг хандивт зарцуулжээ (График 52, 53). Хандив тусламжийн мөнгөн дүнг зориулалтаар нь ангилж харвал баяр ёслол, арга хэмжээ болон сургалтын материалд зориулсан хандивийн хэмжээ хамгийн өндөр байна (График 54).

График 52. Хандив, тусламжид зарцуулсан мөнгөний хэмжээ





График 53. Хамгийн сүүлд өгсөн хандив, тусламжид зарцуулсан мөнгөний хэмжээ, мян.төг



Ярилцлагаас:

Оноо нь хүрэхгүй байсан хэрнээ хандив өгөөд дээд сургуульд орж байсан хүүхдийг мэднэ. Нэг сая төгрөг төлбөрөөсөө гадна өгч байсан. Сургуулийн захиралтай нь орж уулзаад орлоо гэж байсан.

Эрдэмтэн, судлаачдын төлөөлөл

Хүснэгт 5. Хамгийн сүүлд өгсөн хандив, тусламжид зарцуулсан мөнгөний дундаж хэмжээ, анги, курсээр, мян.төг

| | Шатлал | Улсын хэмжээнд | Хот | Хөдөө |
|---------------------------------|--------------------------|----------------|-------|-------|
| СӨБ | Ясли /2 нас х.ртэлх/ | 72.0 | 23.9 | 111.4 |
| | Бага анги /2 нас/ | 44.8 | 47.9 | 43.3 |
| | Дунд анги /3 нас/ | 54.9 | 43.2 | 62.7 |
| | Ахлах анги /4 нас/ | 50.4 | 46.6 | 53.5 |
| | Бэлтгэл анги /5 нас/ | 39.8 | 50.4 | 30.5 |
| ЕБС | Бага анги /1-5р анги/ | 37.4 | 34.8 | 41.7 |
| | Дунд анги /6-9р анги/ | 32.3 | 32.4 | 32.1 |
| | Ахлах анги /10-12р анги/ | 44.4 | 36.2 | 51.3 |
| Их, дээд сургууль, МСҮТ, коллеж | I курс | 40.6 | 46.7 | 37.0 |
| | II курс | 52.1 | 34.4 | 87.5 |
| | III курс | 71.5 | 95.8 | 35.0 |
| | IV курс | 45.0 | 35.8 | 72.5 |
| | V курс | 100.0 | 100.0 | |
| | VI курс | 30.0 | 30.0 | |

График 54. Хандив, тусламжийн зориулалт, зарцуулсан мөнгө, мян.төгрөг




Хандив, тусламжийн хэмжээ дунджаар 20 мянган төгрөгөөс доош байхад өрхийн төсөвт үзүүлэх нөлөөлөл маш бага байна. Харин 40-100 мянга хүрэхэд энэ нь дийлэнх өрхүүдийн хувьд бага

зэрэг нөлөөлөл үзүүлсэн бол 200 мянгаас дээш давах үед мэдэгдэхүйц нөлөөлжээ (График 55). Түүнчлэн өрхийн орлого нэмэгдэхэд хандив тусламжид зарцуулах мөнгөний хэмжээ өсөх хандлагатай байна (График 56).

График 55. Хандив тусламжид зарцуулсан мөнгө өрхийн төсөвт нөлөөлсөн байдал




График 56. Өрхийн орлогын бүлэг болон хандив, тусламжид зарцуулсан зардал, мян.төг




Боловсролын салбарын хандив, тусламжийн зарцуулалт, үр дүн тайлагнал хангалтгүй байна. Дунджаар тал хувьд нь багш нар үр дүнг танилцуулдаг бөгөөд цэцэрлэг, сургуулийн удирдлага танилцуулсан тохиолдол 10 хүрэхгүй хувьтай байна. Их дээд сургууль болон, МСҮТ, коллежийн түвшинд байдал тааруу буюу оролцогчдын 60 гаруй хувь нь огт мэдээлэл өгөөгүй гэжээ (График 57).

График 57. Хандив, тусламжийн хэмжээ зарцуулалт, үр дүнг тайлагнасан байдал



Нийт судалгаанд оролцогчдын 50.8 хувь буюу 569 эцэг эх сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхэдтэйгээ холбоотойгоор төлбөр хураамж өгчээ (График 58). Шатлалаар үзвэл цэцэрлэгийн хүүхэдтэй 560 оролцогчийн 46.6 хувь, ЕБС-д суралцдаг хүүхэдтэй 700 оролцогчийн 56.1 хувь, их дээд сургууль, МСҮТ, коллежид суралцдаг хүүхэдтэй 273 оролцогчийн 53.5 хувь нь төлбөр, хураамж төлжээ. Ойролцоогоор 66 хувь нь 1-2 удаа, 26 хувь нь 3-4 удаа хандив тусламж өгсөн бол үлдсэн 8 орчим хувь нь 5 буюу түүнээс дээш удаа төлжээ (График 59, 60). Төлбөр хураамжийн байдлыг анги курсээр харвал СӨБ-ын бэлтгэл анги, ЕБС-ын бага, дунд анги, мөн их дээд сургуулийн төгсөх ангийн хүүхэдтэй холбоотой төлбөр, хураамж төлөх тохиолдол илүү их гардаг байна (График 61).

График 58. Сүүлийн нэг жилийн хугацаанд төлбөр, хураамж төлсөн эсэх



Ярилцлагаас:

Төлбөр, хураамж аваад байна гэдэг чинь сурч боловсрох эрхийн зөрчил гэж манай иргэний нийгмийнхэн үздэг. Яагаад гэвэл энэ чинь цаашаа ялгаварлан гадуурхалтыг үүсгээд байгаа. Төлж чадсан нь сайн. Төлж чадаагүй хүүхдүүдийг өдөр болгон орж ирж “нүдийг нь ухна”. Эцэг эхэд нь өгөх мөнгө байхгүй учраас тэр хүүхэд маргаашаас нь хичээлдээ очихгүй. Энэ чинь улам бүр гүнзгийрнэ. Нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал, баян ядуугийн ялгаа гарах тусам энэ чинь бүр ноцтой асуудал. Боловсролын чанар муу байгаагаас эцэг эхчүүд хүүхэддээ бусад хүүхдээс илүү хөтөлбөр өгөх тал дээр багшаас гуйдаг. Хоёрдугаарт, энэ нь багшийн ёс зүйтэй холбоотой асуудал. Багш хэрвээ энийг зөвшөөрчих юм бол, бид нийгмээрээ хүлээн зөвшөөрчих юм бол багш хичээлээ муу заагаад нэмэлт давтлага л өгөх сонирхолтой болно.

Багш, ажилтны төлөөлөл

График 59. Сүүлийн нэг жилийн хугацаанд төлбөр, хураамж төлсөн эсэх, шатлалаар





График 60. Төлбөр, хураамж төлсөн давтамж, шатлалаар



График 61. Хамгийн сүүлд төлбөр хураамж төлсөн байдал, анги курсээр



Төлбөр, хураамжийг зориулалтаар нь харвал суралцах үйл ажиллагаатай шууд холбоотой үндсэн хичээлийн ном, сурах бичиг авах шаардлага ЕБС болон их дээд сургуульд их байдаг бол хичээлээс гадуурх баяр ёслол, арга хэмжээний төлбөр хураамж СӨБ-д их тохиолджээ. Мөн аль ч шатлалын хувьд төлбөр, хураамжийн ихэнх хувийг бэлэн мөнгө эзэлж байна (График 62, 63).

График 62. Төлбөр, хураамжийн зориулалт, шатлалаар




График 63. Төлбөр, хураамжийн хэлбэр



Ярилцлагаас:

Төлбөр хураамж бол байнга л авдаг. Манай охин 10 жилд сурдаг. Билет ав гэсэн, ангийн дулаалга, анги засвар, ном ав гэсэн гээд л ирдэг. Тэр болгоныг нь өгөөд л явдаг. Ганцааранг нь өгөхгүй гээд үлдээлтэй нь биш. Өгөхгүй тохиолдолд анги хамт олноосоо ичих, багш нь мөнгөө нэхэх гээд зөндөө асуудал гарч ирнэ

Эрдэмтэн, судлаачдын төлөөлөл

Төлбөр, хураамж төлөх шаардлага ихэнх тохиолдолд багш, сургууль, цэцэрлэгийн захиргааны санаачлагаар үүсчээ. СӨБ-д эцэг, эхийн зөвлөлийн санаачлага өндөр байгаа бол, их, дээд сургууль, МСҮТ, коллежийн хувьд багшийн санаачлага илүү их байна. Төлбөр, хураамжийг санаачлагч тал өөр өөр байгаа боловч түүнийг хүлээн авагч нь аль ч шатлалын хувьд ихэвчлэн багш нар байна (График 64).

График 64. Төлбөр, хураамжийг санаачлагч



График 65. Төлбөр, хураамж хүлээн авсан хүн



График 66. Төлбөр, хураамжийг өгсөн арга хэлбэр



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Сүүлийн нэг жилийн хугацаанд төлбөр, хураамж төлсөн 569 оролцогчийн 40 хувь нь 20.0 мянга хүртэлх төгрөг, 36 хувь нь 20.0-60.0 мянгыг зарцуулсан бол үлдсэн 24 хувь нь 60.0 мянгаас дээш төгрөгийг зарцуулжээ. Харин хөдөөгийн өрхийн хувьд их, дээд сургууль, МСҮТ, коллежид суралцдаг хүүхэдтэй холбоотой төлсөн төлбөр хураамж харьцангуй өндөр байна (График 67, 68). Төлбөр, хураамжийн зориулалтыг харвал ном сурах бичиг, давтлага, дамжаа ихэнхийг эзэлж байгаа бөгөөд энэ хандлага ЕБС болон их дээд сургуульд нийтлэг байна (График 69).

График 67. Төлбөр, хураамжид зарцуулсан мөнгөний хэмжээ, хувиар






График 68. Төлбөр, хураамжид зарцуулсан мөнгөний хэмжээ, хот, хөдөөгөөр, мян.төг



Хүснэгт 8. Хамгийн сүүлд төлсөн төлбөр, хураамжид зарцуулсан мөнгөний хэмжээ, анги курсээр, мян.төг

| Шатлал | Улсын хэмжээнд | Хот | Хөдөө | |
|---------------------------------|--------------------------|-------|-------|-------|
| СӨБ | Ясли /2 нас хүртэлх/ | 87.1 | 90.7 | 83.6 |
| | Бага анги /2 нас/ | 33.2 | 30.0 | 34.6 |
| | Дунд анги /3 нас/ | 44.9 | 44.7 | 45.0 |
| | Ахлах анги /4 нас/ | 32.6 | 28.7 | 38.1 |
| | Бэлтгэл анги /5 нас/ | 55.1 | 64.9 | 33.8 |
| ЕБС | Бага анги /1-5р анги/ | 48.5 | 48.1 | 49.3 |
| | Дунд анги /6-9р анги/ | 64.6 | 69.8 | 56.5 |
| | Ахлах анги /10-12р анги/ | 78.4 | 59.0 | 94.5 |
| Их, дээд сургууль, МСҮТ, коллеж | I курс | 49.2 | 61.3 | 25.0 |
| | II курс | 62.3 | 37.1 | 79.1 |
| | III курс | 179.0 | 105.0 | 210.7 |
| | IV курс | 127.6 | 37.5 | 282.1 |
| | V курс | 60.0 | 20.0 | 100.0 |

График 69. Төлбөр, хураамжийн зориулалт, зарцуулсан мөнгө, мян.төгрөг



Төлбөр, хураамжийн хувьд өрхийн төсөвт үзүүлэх нөлөө нь хандив, тусламжтай харьцуулахад өндөр байна. 10 мянга хүртэл төгрөг байхад нөлөөлөл маш бага байсан бол мөнгөний дүн нэмэгдэх хэрээр нөлөөлөл нь нэмэгджээ. Тухайлбал, төлбөр, хураамжийн хэмжээ 200 мянган төгрөгөөс дээш давахад мэдэгдэхүйц нөлөө нь 10 орчим хувиар огцом нэмэгдэж байна (График

БҮЛЭГ 3 БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ, ЁС ЗҮЙ, АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Боловсролын салбарын дотоод үйл ажиллагаа, томилгоо, шагнал урамшуулал, санхүү төсөв, худалдан авалт, өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт ил тод нээлттэй бус, авлига, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил байгааг ярилцлагын дүн харуулж байна. Боловсролын салбарт төсөв, санхүүгийн ил тод байдал хангалтгүй байна. Дийлэнх багш, ажилчид салбарын болон байгууллагын төсөв, өмч хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээлэлгүй байна. Энэ байдал нь авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хардлага сэрдлэгэ газар авахад хүргэжээ.

3.1 Томилгоо, албан тушаал, шагнал урамшуулал

Багш, ажилтнуудын үзэж байгаагаар салбарын болон сургууль, цэцэрлэгийн хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой ёс зүйн асуудлууд, авлига, ашиг сонирхлын зөрчил байна. Юуны өмнө, удирдах ажилтны ёс зүй, ур чадвар, ашиг сонирхлын зөрчил, түүнээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалт, дарамт, шахалт, шударга бус асуудлууд ихээхэн шүүмжлэл дагуулж байна. Тухайлбал, ах дүү, танил талтай хүмүүс хурдан албан тушаал дэвшдэг, өмссөн зүүсэн, царай зүсээр ялгадаг гэх зэрэг асуудал яригдаж байна.

Ярилцлагаас:

Би сумын сургуульд багшаар ажиллаж байгаад хотын сургуульд танил талаараа дамжуулан ажилд орсон юм. Ажилд ороод дөрвөн сар болж байтал сургуулийн захирал хавчин боогдуулсан. Тэгээд хамт ажилладаг хүмүүстээ энэ байдлаа хэлтэл мөнгө өгчих чамаас юм авах гэсэндээ тэгэж байгаа юм гэхээр нь нэгсая төгрөг өгсөн. Тэрнээс хойш байдал нь эрс өөрчлөгдөөд намайг сайн ажиллаж чадах юм байгаа биздээ гэсэн. Энэ тохиолдлыг бол манай удирдлага өөрөө санаачилсан. Би бол ажлаа алдахгүй гэсэндээ өгсөн. Энэ нь манай гэр бүлийн санхүүд багахан хугацаанд хүндрэл учруулсан.

Багш, ажилтны төлөөлөл

Боловсролын байгууллага дахь хүний нөөцийн талаарх эцэг эхчүүдийн ойлголт, төсөөллийг судлахад оролцогчдын 50 орчим хувь нь дээрх асуудлаар авлига их гэсэн төсөөлөлтэй байна (График 73). Чанарын судалгааны ярилцлагаас үзэхэд ажилд орох, албан тушаал дэвшихтэй холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчил гол асуудал байна. Зарим тохиолдолд үндэслэлгүй шагнал гардуулах тохиолдол байдаг хэдий ч, шагнал, зэрэг дэв олгох асуудал харьцангуй шударга явагддаг гэжээ.

График 73. Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, албан тушаал дэвших, томилгоо, шагнал урамшуулалтай холбоотой авлигын талаарх төсөөлөл



Ярилцлагаас:

Ажилд ороход, сонгон шалгаруулалтад гурван хүн тэнцсэн байлаа гэж бодъё. Тэгвэл нэг танил талтай нь л орох жишээтэй. Мөн дээд яам, удирдах байгууллагуудаас тодорхой нэр заасан хүмүүсийг сургалтдаа хамруул, тохирох албан тушаалд ав гэх зэрэг албан бичгүүд байнга ирж байдаг. Ер нь албан тушаалаа ашиглан үүрэг өгөх, биелүүлэхийг шаардах асуудлууд байдаг. Мөн оюутан элсүүлэх явцад БХИС-д оруул гэсэн албан бичгүүд их ирэх жишээтэй. Энэ мөн л албан тушаалаа ашиглан дээд байгууллагаас шууд үүрэг болгож байгаа нэг хэлбэр. Тэгэхээр томилгоонд асуудал байсаар ирсэн гэж хэлж болно. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа зүйл байхгүй.

Багш, ажилтны төлөөлөл

Ярилцлагаас:

Би захиргаанд байхдаа магадланд орох гэсэн сургуулийн удирдлагуудтай хоёр, гурван удаа таарсан. Хоол ундаар дайлах, машин тэргээр үйлчлэх энэ тэр бол тэс өөр, гайхамшигтай л юм байна лээ. Тэрийг хахууль гэж үзэх юм уу? Юу гэж үзэх юм мэдэхгүй. Аймаар дайлж цайлна, унаа тэргээр үйлчилнэ, “юу хэрэгтэй байна, манай сургуульд хүүхэд оруулж болно” гээд захирал нь санал тавьж байна ш дээ. Тэрийг одоо юу гэдгийг би хэлж сайн мэдэхгүй байна. Их л таатай сайхан мэдрэмж.

Багш, ажилтны төлөөлөл

Ярилцлагаас:

Маш их байна. Бүр даамжирсан. Дээрээс л яваад байдаг. Боловсролын байгууллага бол нам биш гэдгийг ойлгуулах хэрэгтэй байна. Намын харъяалал хэт их байна. ЗДТГ-аас дарамт их ирнэ. Урьдчилан сэргийлэх ажил хийгдэхгүй байна. Өөрсдөө оролцож байгаа болохоор хянаж чадахгүй шүү дээ. Аль ч сургуульд намын захирлууд ирдэг. Тэгээд тэр хүн хүмүүсийг шударга бус үнэлдэг, өөрийнхөө тойрон хүрээлэгчдийг бий болгодог. Хүрээлэлд нь орохын тулд ёс зүйн янз бүрийн зөрчил гаргаж бялдуучилна. Манай сургуульд Ардын нам гарахаар гардаг баг байна, Ардчилсан нам гарахаар гардаг баг байна. Бэлдсэн ийм хоёр команд байдаг. Хурал болохоор Ардчилсан намынхан та нар ажлаа хийхгүй байна гэгцгээдэг. Ийм гаж тогтолцоо байгаа тохиолдолд хэзээ ч бодит юм гарахгүй. Шинжлэх ухааны байгууллагыг ийм болгочихсон.

Багш, ажилтны төлөөлөл

Боловсролын байгууллагын үйл ажиллагаа, томилгоонд улс төрийн нам, улс төрийн албан тушаалтны нөлөөлөл их, энэ нь боловсролын үйлчилгээ, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж буйг судалгаанд оролцогчид баталж байна. Тухайлбал, зүй бус арга замаар томилогдсон удирдлагын хувьд чадвар муу, салбарын онцлогийг сайн мэддэггүй, гаргаж буй шийдвэр нь оновчгүй, багш, ажилтныг сонгон шалгаруулж авахдаа танил тал, мөнгө харах нь хэвийн үзэгдэл болсон гэж судалгаанд оролцогчид үзэж байна. Энэ нь эргээд удирдах албан тушаалтан ажиллагсаддаа хариуцлага тооцож, шаардлага тавьж чадахгүйд хүрэх, хамт олны уур амьсгалыг эвдэх үр дүнд хүргэдэг байна.


Ярилцлагаас:

Орон тоо өөрчлөгдөх, сул орон тоо гарах үед өөрийнхөө намын, сурталчилгаанд явсан гэдэг ч юм уу тодорхой захиалгат хүмүүсийг тавьдаг. Тавихдаа холбогдох хүмүүст энэ хүнийг яаж ийж байгаад л гаргана шүү гэж чиглэл өгдөг. Энэ нь удирдах ажилтны ёс зүйгүй байдал гэж үзэж байна. Ажил сайжруулах тал дээр өмнөх хүний хийж байсан юм бол бүгд буруу. Би бол бүгдийг нь өөрчилж шинэчлээд, цоо шинээр юм хийнэ гээд яваад байгаа юм. Энэ нь төрийн байгууллагын хэвийн, тогтвортой үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байгаа юм.

Эрдэмтэн судлаачдын төлөөлөл

Чанарын судалгаанд хамрагдсан багш, ажилтнуудаас албан тушаал, мэргэжлийн зэрэг дэв ахих зэрэг шалтгаанаар хэн нэгэнд мөнгө, бэлэг өгч байсан эсэхийг дугтуйтай асуулт буюу хариултыг нууцалсан асуулгаар тодруулсан. Нийт 75 оролцогчийн 13 хувь нь буюу 10 хүн албан тушаал, мэргэжлийн зэрэг дэв ахих зэрэг шалтгаанаар хэн нэгэнд мөнгө, бэлэг сэлт өгч байжээ (График 74).

График 74. Албан тушаал дэвших, мэргэжлийн зэрэг дэв ахих зорилгоор хэн нэгэнд мөнгө, бэлэг өгч байсан эсэх



Ярилцлагаас:

Ажилд орохоор ирж байгаа багш нь өөрөө 1.0-3.0 сая төгрөг бэлдэж ирээд намайг аваач гэдэг. Хөдөө ажлын байр хомс, орон тоо цөөн учир тэр хүнд ажилд орох нь л чухал байна.

Багш, ажилтны төлөөлөл

Ярилцлагаас:

Яг баримттай гаргаад ирчихсэн юм байхгүй ч, мөнгө төлж албан тушаалд очдог гэдэг асуудал маш их яригддаг. Бүр тодорхой ханштай. Багшийг ажилд оруулахад 300 мянгаас сарын цалин хүртэл, өөрөөр хэлбэл 300-600, 700 мянга хүртэл. Захирлын хувьд 10 сая эсвэл түүнээс дээш байж магадгүй. 7, 8 сая төгрөг гэж нэг хэсэг яригдаж байсан. Тэгээд юмны үнэ нэмэгддэг гэдэг шиг ханш нь нэмэгдээд яваад байх шиг байгаа юм.

Эрдэмтэн, судлаачдын төлөөлөл

Багш, ажилтны төлөөлөл

Ярилцлагаас:

10 гаруй жил ажиллахдаа нэг ч шагнал урамшуулал авч байгаагүй. Докторант болохдоо 5000 доллар өгсөн бол асуудалгүй явах байсан байх. Нэг найз маань "боловсролын салбарт өндөр албан тушаалд ажилладаг хүн шагнал авах бол хэлээрэй" гэж байна гэж хэлж байсан.

Багш, ажилтны төлөөлөл

3.2 Боловсролын салбарын төсөв, өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт

Салбарын болон байгууллагын төсөв, мөнгө санхүүгийн асуудлаар багш ажилтнууд мэдээлэлгүй байна. Ярилцлагын дүнгээс үзвэл ороцлогчдын дийлэнх аль ч шатлалд төсөв, хөрөнгийн зарцуулалт, худалдан авах ажиллагааны талаар хангалттай мэдээлэл авдаг гэх хүн цөөн байна. Мэдээлэл ил тод бус, хаалттай учраас багш, ажилтнуудын дунд хардлага сэрдлэг ихтэй, ялангуяа их дээд сургуулийн хувьд шүүмжлэл их байна. Олонхи тохиолдолд өмч, хөрөнгө, худалдан авалтын мэдээлэл захирал, нягтлан хоёрын хүрээнээс гадагш гардаггүй, төсвийг ямар нэг хяналтгүй, дураар зарцуулах хандлага байдаг байна.

Ярилцлагаас:

Төсөв, тайланг шалгаад хараад байдаггүй. Хэчнээн ил тод гаргаж харуулдаг ч гэсэн цаагуураа юм хийж л байгаа. Худлаа баримт гаргаж харуулаад ил тод гээд байвал хэцүү.

Багш, ажилтны төлөөлөл

Ярилцлагаас:

Шударга бус. Гарсан хэд нь хувааж авна. Өөртөө хэрэгтэй юм худалдаж авна, эсвэл хэрэггүй байсан ч худалдаж авна. Хэрэгтэй ш дээ аваад тавьчих гээд л. Энэ хүнд томиллолт өгье, томиллолтоор тийшээ явуулчихья гээд. Нөгөөх нь хот явж зугаалж байгаад ирдэг. Хуучин компьютерыг шинэ компьютерийн үнээр шахна. Шал будна, 7 хоноод арилна. Хамгийн муу юмыг хамгийн өндөр үнээр авна. Муухан юм байсан байна лээ, за яахав гээд л орхино. Ажилд орохдоо мөнгө өгч ороод, нөгөө мөнгөө олох гэж ажилладаг.

Багш, ажилтны төлөөлөл

Салбарын томоохон хөтөлбөр, төслүүд, яам, агентлагын түвшин дэх хөрөнгө оруулалт, худалдан авалт, тэдгээрийн зарцуулалт, тайлагнал багагүй шүүмжлэл дагуулж байна. Тухайлбал, лаборатори, сургалтын тоног төхөөрөмж болон тусгай хөтөлбөрүүдэд зарцуулсан хөрөнгийн мэдээлэл, үр ашиг, үр дүн тодорхойгүй гэх шүүмжлэл байна. Тоон судалгаанд оролцогч эцэг эхчүүдийн хувьд мөн адил энэ салбарын худалдан авах ажиллагаанд авлига, ашиг сонирхлын зөрчил их бий гэсэн ойлголт, төсөөлөлтэй байна (График 75).

График 75. Худалдан авах үйл ажиллагаанд дахь авлигын талаарх төсөөлөл




Ярилцлагаас:

Байгууллагын засвар, хөрөнгө оруулалтаа хөөцөлдөхийн тулд танил талаараа дамжуулж байж авдаг. Хөрөнгө оруулалтаа авахын тулд хоолонд оруулах, сонирхол нь ямар байна гэдгээс хамаарч тодорхой хэмжээнд авлига өгдөг. Бид нар шиг хөдөөнөөс богино хугацаагаар очиж буй хүмүүст цаг хугацаа чухал байдаг. Ажлаа хурдан амжуулахын тулд өгдөг. Өгөхгүй бол бүтдэггүй.

Багш, ажилтны төлөөлөл

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүд салбарын худалдан авах ажиллагааны талаар үл итгэх байдал, хардлага, сэжиг ихтэй байна. Салбарын томхон хэмжээний худалдан авах ажиллагааны зар, мэдээлэл ихэнхдээ нээлттэй байдаг боловч зарим тендерийн хувьд хугацааг нь тулгаж, олон хүнд хүрдэггүй сонинд мэдээлдэг, эсвэл зарыг танил тал, байгууллагаас өөрсдөө асууж сураглаж олж авдаг, шалгараагүй шалтгааны талаар мэдээлэл өгдөггүй гэх шүүмжлэлүүд гарч байна. Харин сургууль, цэцэрлэгийн түвшин дэх бага үнийн дүнтэй худалдан авах ажиллагааны хувьд нээлттэй бус, хэрхэн явагддаг талаарх мэдээлэл бага байна. Худалдан авах ажиллагааны шударга байдлыг хувийн хэвшлийн оролцогчдоор үнэлүүлэхэд 3.02 буюу дунд зэрэг гэсэн үнэлгээг өгсөн. Худалдан авах ажиллагааны эхлэл болон төгсгөл хэсгийг харьцангуй шударга, харин үнэлгээний хороо байгуулах болон тендер шалгаруулах үйл явц хамгийн шударга бус явагддаг гэж үзжээ (График 76). Үнэлгээг баллын үнэлгээний аргаар үнэлүүлсэн. Ингэхдээ үнэлгээний утгыг 5 бол огт шударга биш бөгөөд нэг бол маш шударга байхаар сонгон авсан.

График 76. ХАА-ны шударга байдлын үнэлгээ




Ярилцлагаас:

Заавал яриа хийхгүй бол бүтэхгүй. Бусад компаниудыг яриа хийхээс өмнө өрсөж ярих хэрэгтэй болдог. Яриаг хийхдээ ихэвчлэн үнийн дүнгийн 8-10 хувиар тохирдог. Тав орчим сая төгрөгөөр тохирч байсан тохиолдол бий. Авлига ихэвчлэн бэлэн мөнгөөр, нууц дансаар явагддаг. Тендерийн шалгуур гол нууц зэвсэг нь болдог. Ажлын даалгавар өгөхөөс өмнө л аль хэдийн тохироо хийж, нүхээ малтсан байдаг. Танил тал хэдий чухалч, харилцан тохиролцооны үндсэн дээр танил болдог.

Хувийн хэвшлийн төлөөлөл

Хувийн хэвшлийн төлөөллийн үзэж байгаагаар салбарын худалдан авах ажиллагаанд оролцохдоо заавал ямар нэг хэлцэл, тохироо хийх шаардлага гардаг бөгөөд өгөх, авах, хувь тохирох нь бичигдээгүй хууль болсон гэж үзэж байна. Ажил авахын тулд зуучлагчаар дамжуулж хөөцөлддөг, үнийн дүнгийн 5-10 хувьтай тэнцэх хээл хахууль өгдөг, ихэвчлэн ажил хайж буй гүйцэтгэгч нар өөрсдөө санал тавьдаг гэх мэдээллийг өгч байна. Тендерийн үнэлгээний хорооны дарга, гишүүд, яамны ТНБД, газрын дарга нар илүү холбоотой байдаг, тендерийн шалгуур үзүүлэлтийг өгөхөөр тохирсон аж ахуйн нэгжид тохируулдаг гэх хардлага байна. Чанарын судалгаанд хамрагдсан оролцогчдоос ийм тохиолдол байсан эсэхийг тодруулахад 13 аж ахуйн нэгжийн 6 нь холбогдох албан тушаалтанд мөнгө, бэлэг сэлт өгөх, дайлж цайлах замаар салбарын худалдан авах ажиллагаанд нөлөөлж байсан гэжээ (График 77).

График 77. Салбарын худалдан авах ажиллагаатай холбоотойгоор мөнгө, бэлэг сэлт өгөх, дайлж цайлсан эсэх



Ярилцлагаас:

Тендерт шударгаар ороод шалгарна гэсэн ойлголт байдаггүй. Тодорхой хэмжээнд нөлөөлж чадах, боломжтой ажилдаа л оролцдог. Бараг үнэлгээ тогтсон гэж хэлж болно. 100.0 сая төгрөгөөс бага дүнтэй ажлыг бол үнэлгээний хороо нь мэдээд шийддэг байхад 100.0 сая төгрөгөөс дээш дүнтэй ажлыг дарга нар нь мэддэг байх жишээтэй. Ер нь ажлын үнийн дүнгийн хувь тохирдог. 5-10 хувь гэсэн жишиг байдаг.

Хувийн хэвшлийн төлөөлөл

Ярилцлагаас:

Үдийн цайны хувьд сургуулийн захирлууд өөрсдөө шийвэрээ гаргадаг учир захирлын танил эсвэл хамаатан садангийн хүмүүс сонгогдоод байдаг. Сонголтыг нь харахаар ихэндээ жижиг цэхүүд байдаг. Манай санал өгсөн 100 орчим газар гэхэд удирдлагууд нь шууд л 10 хувь өгөх үү гэдэг. Манай байгууллагын хувьд төсөв нь маш бага байсан учраас тэр 10 хувийг өгөхгүй гэсэн.

Хувийн хэвшлийн төлөөлөл

БҮЛЭГ 4 ЁС ЗҮЙ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ, АВЛИГЫН ШАЛТГААН НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Боловсролын салбар дахь асуудлын шалтгаан нөхцөл шатлал, хүрээ хязгаараас шалтгаалан харилцан адилгүй байна. Салбарын хэмжээнд ёс зүй тааруу, багш, ажилтнууд, удирдлагууд их бага хэмжээг үл харгалзан ёс зүйгүй байдал, авлига, ашиг сонирхлын зөрчлийг байх зүйл мэтээр хүлээн зөвшөөрсөн байгаа нь салбарын ерөнхий дүр зургийг муу харагдуулж байна. Мөн эдгээр асуудалд тавих анхаарал, зохион байгуулалт дутагдалтай, хяналт, хариуцлагын тогтолцоо суларсан явдал нь ёс суртахуунгүй байдал өргөн хүрээнд тархах шалтгаан болжээ. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 59 хувь буюу 661 оролцогч боловсролын байгууллагууд ёс зүйн зөрчил, авлигын асуудалдаа хяналт тавьж, хариуцлага тооцож огт чадахгүй байна гэж үзэж байна. Чадаж байна гэсэн үзүүлэлт ердөө 5 хувь байна (График 78).


График 78. Ёс зүй, авлигын асуудалд хяналт тавьж, хариуцлага тооцож байгаа эсэх



4.1 Шалтгаан нөхцөл

Тоон судалгаанд оролцогчид бэлэг сэлт, мөнгө авах нь зуршил болсон, салбарын хяналт, хариуцлагын тогтолцоо сул, мөн цалин бага байгааг хамгийн гол шалтгаанд тооцож байна (График 79). Харин ярилцлагын дүнгээс үзэхэд шатлалаас хамаарч голлон нөлөөлж буй тодорхой шалтгаанууд байна. Тухайлбал, СӨБ-д цэцэрлэгийн хүртээмж болон багшлах боловсон хүчний хүрэлцээ муу байгаа нь голлох шалтгаан байгаа бол, ЕБС-ийн шатанд эцэг эхчүүдийн чанартай, илүү боловсрол хүүхэддээ олгох гэсэн хүсэл сонирхол нэг гол шалтгаанд тооцогдож байна. Боловсролын байгууллагын дотоод үйл ажиллагаанд улс төрийн зүй бус нөлөөлөл, багш нарын хувьд цалин бага байгаа нь нэг суурь шалтгаан болж байна. Нөгөө талдаа эдгээр суурь шалтгаанаас үүдэлтэй бий болсон зүй бус байдал нь эргээд хувийн ашиг сонирхлоо авлига, хээл хахуулийн замаар хангах зуршлыг бий болгожээ.


График 79. Багш, ажилтан бэлэг сэлт, мөнгө авч байгаа шалтгаан



4.2 Урьдчилан сэргийлэх арга зам

Судалгаанд оролцогчид юуны өмнө хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх нь салбар дахь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хамгийн чухал, үр дүнтэй арга зам гэж үзэж байна. Үүний зэрэгцээгээр цалин урамшуулал, салбарын төсөв, санхүүжилтийг нэмэгдүүлэх, ёс зүй, хандлагыг өөрчлөх шаардлагатай гэжээ (График 80). Түүнчлэн тодорхой шатлал дахь авлигаас сэргийлэхийн тулд чанар, үйлчилгээний ялгаатай байдлыг арилгах, ижил стандарт мөрдүүлэх, тусгай сургууль гэх мэт эцэг эхчүүд шударга бусаар өрсөлдөх нөхцлийг бий болгохгүй байх, боловсролын салбарт иргэний нийгмийн оролцоо, хяналтыг бодитой нэмэгдүүлэх хэрэгтэй гэх саналууд ярилцлагуудаас гарч байв. Тендер, худалдан авах ажиллагааны хувьд томоохон тендерийн хяналтыг сайжруулах, тендер сонгон шалгаруулж байгаа албан тушаалтнуудыг ил тод, дүрэм журмын дагуу зөв сонгох, шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгож, баримтжуулах зэрэг саналууд гарч байна. Хэдийгээр авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг нэрлэж байгаа боловч авлигыг бууруулж чадна гэх итгэл үнэмшил бага, төр, захиргааны байгууллагад хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл байгаа эсэхэд эргэлзсэн хандлага нэлээд ажиглагдаж байна.

График 80. Боловсролын салбарт ёс зүй, авлигаас сэргийлэх хамгийн үр дүнтэй арга (нээлтэй асуулт)



ХАВСРАЛТ 1 ЧАНАРЫН СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЖАГСААЛТ

Багш, ажилтан, төрийн захиргааны байгууллагын төлөөллийн мэдээлэл

| № | Байршил | Шатлал | Хүйс | Боловсрол | Албан тушаал |
|-------------|---------|---|---------|------------|------------------------------|
| Оролцогч 1 | Хөдөө | ЕБС | Эмэгтэй | Дипломын | Нийгмийн ажилтан |
| Оролцогч 2 | Хөдөө | ЕБС | Эмэгтэй | Магистр | Сургалтын менежер |
| Оролцогч 3 | Хөдөө | СӨБ | Эмэгтэй | Магистр | Эрхлэгч |
| Оролцогч 4 | Хөдөө | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эмэгтэй | Магистр | Мэргэжилтэн |
| Оролцогч 5 | Хөдөө | ЕБС | Эрэгтэй | Магистр | Захирал |
| Оролцогч 6 | Хөдөө | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эрэгтэй | Доктор | Тэнхимийн эрхлэгч |
| Оролцогч 7 | Хөдөө | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эмэгтэй | Магистр | Багш |
| Оролцогч 8 | Хөдөө | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эмэгтэй | Магистр | Сургалтын менежер |
| Оролцогч 9 | Хөдөө | СӨБ | Эмэгтэй | Дипломын | Багш |
| Оролцогч 10 | Хот | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эмэгтэй | Магистр | Дарга |
| Оролцогч 11 | Хот | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эмэгтэй | Бакалавр | Мэргэжилтэн |
| Оролцогч 12 | Хот | ЕБС | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 13 | Хот | СӨБ | Эмэгтэй | Магистр | Эрхлэгч |
| Оролцогч 14 | Хөдөө | ЕБС | Эрэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 15 | Хөдөө | ЕБС | Эмэгтэй | Бакалавр | Захирал |
| Оролцогч 16 | Хөдөө | СӨБ | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 17 | Хөдөө | СӨБ | Эмэгтэй | Магистрант | Эрхлэгч |
| Оролцогч 18 | Хөдөө | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эмэгтэй | Бакалавр | Санхүүч |
| Оролцогч 19 | Хөдөө | ЕБС | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 20 | Хөдөө | ЕБС | Эмэгтэй | Бакалавр | Сургалтын менежер |
| Оролцогч 21 | Хөдөө | Их, дээд сургууль, МСҮТ коллеж | Эмэгтэй | Докторант | Багш |
| Оролцогч 22 | Хөдөө | Их, дээд сургууль, МСҮТ коллеж | Эрэгтэй | Магистр | Захирал |
| Оролцогч 23 | Хөдөө | СӨБ | Эмэгтэй | Магистр | Эрхлэгч |
| Оролцогч 24 | Хот | Их, дээд сургууль, МСҮТ коллеж | Эмэгтэй | Магистр | Багш |
| Оролцогч 25 | Хот | ЕБС | Эрэгтэй | Магистр | Захирал |
| Оролцогч 26 | Хот | ЕБС | Эмэгтэй | Магистр | Захирал |
| Оролцогч 27 | Хот | Их, дээд сургууль, МСҮТ коллеж | Эмэгтэй | Магистр | Багш |
| Оролцогч 28 | Хот | Их, дээд сургууль, МСҮТ коллеж | Эмэгтэй | Магистр | Сургалтын албаны мэргэжилтэн |
| Оролцогч 29 | Хот | Их, дээд сургууль, МСҮТ коллеж | Эмэгтэй | Докторант | Сургалтын албаны менежер |

| | | | | | |
|-------------|-------|---|---------|---------------|-------------------|
| Оролцогч 30 | Хот | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эрэгтэй | Бакалавр | Ахлах мэргэжилтэн |
| Оролцогч 31 | Хот | ЕБС | Эрэгтэй | Бакалавр | Нийгмийн ажилтан |
| Оролцогч 32 | Хот | Их, дээд сургууль, МСҮТ коллеж | Эмэгтэй | Доктор | Тэнхмийн эрхлэгч |
| Оролцогч 33 | Хот | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эмэгтэй | Магистр | Мэргэжилтэн |
| Оролцогч 34 | Хот | СӨБ | Эмэгтэй | Магистр | Эрхлэгч |
| Оролцогч 35 | Хот | СӨБ | Эмэгтэй | Магистр | Багш |
| Оролцогч 36 | Хот | СӨБ | Эмэгтэй | Магистр | Эрхлэгч |
| Оролцогч 37 | Хот | СӨБ | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 38 | Хот | СӨБ | Эмэгтэй | Бакалавр | Эрхлэгч |
| Оролцогч 39 | Хот | СӨБ | Эмэгтэй | Магистрант | Багш |
| Оролцогч 40 | Хот | СӨБ | Эмэгтэй | Магистр | Эрхлэгч |
| Оролцогч 41 | Хот | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 42 | Хөдөө | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эмэгтэй | Магистр | Сургалтын менежер |
| Оролцогч 43 | Хөдөө | ЕБС | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 44 | Хөдөө | СӨБ | Эмэгтэй | Магистр | Багш |
| Оролцогч 45 | Хөдөө | СӨБ | Эмэгтэй | Бакалавр | Эрхлэгч |
| Оролцогч 46 | Хөдөө | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эрэгтэй | Магистр | Мэргэжилтэн |
| Оролцогч 47 | Хот | ЕБС | Эмэгтэй | Магистр | Багш |
| Оролцогч 48 | Хот | ЕБС | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 49 | Хот | ЕБС | Эмэгтэй | Бакалавр | Нийгмийн ажилтан |
| Оролцогч 50 | Хөдөө | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 51 | Хөдөө | СӨБ | Эмэгтэй | Магистр | Багш |
| Оролцогч 52 | Хот | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эрэгтэй | Магистр | Хичээлийн эрхлэгч |
| Оролцогч 53 | Хот | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эрэгтэй | Магистр | Дарга |
| Оролцогч 54 | Хот | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эрэгтэй | Бакалавр | Мэргэжилтэн |
| Оролцогч 55 | Хот | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эрэгтэй | Бакалавр | Мэргэжилтэн |
| Оролцогч 56 | Хот | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эмэгтэй | Доктор | Дарга |
| Оролцогч 57 | Хот | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эмэгтэй | Дэд профессор | Багш |
| Оролцогч 58 | Хот | СӨБ | Эмэгтэй | Магистр | Эрхлэгч |
| Оролцогч 59 | Хөдөө | ЕБС | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 60 | Хөдөө | СӨБ | Эмэгтэй | Бакалавр | Эрхлэгч |
| Оролцогч 61 | Хөдөө | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эрэгтэй | Бакалавр | Захирал |

| | | | | | |
|-------------|-------|---|---------|----------|-------------------|
| Оролцогч 62 | Хот | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эмэгтэй | Магистр | Багш |
| Оролцогч 63 | Хөдөө | СӨБ | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 64 | Хот | ЕБС | Эрэгтэй | Магистр | Сургалтын менежер |
| Оролцогч 65 | Хот | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эрэгтэй | Магистр | Захирал |
| Оролцогч 66 | Хот | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эрэгтэй | Магистр | Мэргэжилтэн |
| Оролцогч 67 | Хот | ЕБС | Эмэгтэй | Магистр | Сургалтын менежер |
| Оролцогч 68 | Хот | ЕБС | Эмэгтэй | Дипломын | Багш |
| Оролцогч 69 | Хөдөө | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эрэгтэй | Доктор | Дарга |
| Оролцогч 70 | Хөдөө | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эрэгтэй | Магистр | Мэргэжилтэн |
| Оролцогч 71 | Хот | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эмэгтэй | Доктор | Захирал |
| Оролцогч 72 | Хот | СӨБ | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 73 | Хот | СӨБ | Эмэгтэй | Бакалавр | Багш |
| Оролцогч 74 | Хот | Их дээд сургууль, МСҮТ, коллеж | Эмэгтэй | Магистр | Багш |
| Оролцогч 75 | Хот | Боловсролын төрийн захиргааны байгууллага | Эмэгтэй | Магистр | Дарга |

Эрдэмтэн судлаач, төрийн бус байгууллагын төлөөллийн мэдээлэл

| № | Байршил | Хүйс | Боловсрол | Ажил, мэргэжил, төлөөлж буй байгууллага |
|-------------|---------|---------|-----------|---|
| Оролцогч 1 | УБ | Эрэгтэй | Доктор | Салбарын эрдэмтэн судлаач |
| Оролцогч 2 | УБ | Эмэгтэй | Магистр | ТББ |
| Оролцогч 3 | Хөдөө | Эрэгтэй | Магистр | ТББ |
| Оролцогч 4 | УБ | Эрэгтэй | Магистр | ТББ |
| Оролцогч 5 | Хөдөө | Эрэгтэй | Доктор | Ахмад багш |
| Оролцогч 6 | УБ | Эмэгтэй | Магистр | ТББ |
| Оролцогч 7 | УБ | Эрэгтэй | Магистр | ТББ |
| Оролцогч 8 | УБ | Эрэгтэй | Магистр | ТББ |
| Оролцогч 9 | УБ | Эмэгтэй | Доктор | Салбарын эрдэмтэн судлаач |
| Оролцогч 10 | УБ | Эмэгтэй | Докторант | Салбарын эрдэмтэн судлаач |
| Оролцогч 11 | УБ | Эмэгтэй | Доктор | ТББ |
| Оролцогч 12 | УБ | Эмэгтэй | Магистр | ТББ |
| Оролцогч 13 | Хөдөө | Эмэгтэй | Магистр | Салбарын эрдэмтэн судлаач |
| Оролцогч 14 | УБ | Эрэгтэй | Доктор | Салбарын эрдэмтэн судлаач |
| Оролцогч 15 | УБ | Эмэгтэй | Доктор | Салбарын эрдэмтэн судлаач |
| Оролцогч 16 | УБ | Эрэгтэй | Доктор | Салбарын эрдэмтэн судлаач |
| Оролцогч 17 | УБ | Эмэгтэй | Магистр | Салбарын ахмад багш |

Боловсролын салбарын худалдан авах ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгж

| № | Байршил | Хүйс | Боловсрол | Байгуулагдсан он | Үйл ажиллагааны чиглэл |
|-------------|---------|---------|-------------|------------------|---|
| Оролцогч 1 | УБ | Эмэгтэй | Бакалавр | 2013 | Барилгын зураг төсөл |
| Оролцогч 2 | УБ | Эмэгтэй | Бакалавр | 2007 | Дүрэмт хувцас |
| Оролцогч 3 | УБ | Эмэгтэй | Бакалавр | 2000 | Ном сурах бичиг |
| Оролцогч 4 | УБ | Эрэгтэй | Бакалавр | 1991 | Ном сурах бичиг |
| Оролцогч 5 | Хөдөө | Эрэгтэй | Бакалавр | 2010 | Үдийн цай |
| Оролцогч 6 | Хөдөө | Эрэгтэй | Тусгай дунд | 2008 | Барилга |
| Оролцогч 7 | УБ | Эрэгтэй | Бакалавр | 2010 | Барилга |
| Оролцогч 8 | УБ | Эрэгтэй | Магистр | 2014 | Барилгын зураг төсөл |
| Оролцогч 9 | УБ | Эрэгтэй | Бакалавр | 2010 | Барилга, их засвар |
| Оролцогч 10 | УБ | Эмэгтэй | Магистрант | 2003 | Үдийн цай |
| Оролцогч 11 | УБ | Эмэгтэй | Бакалавр | 2009 | Дүрэмт хувцас |
| Оролцогч 12 | Хөдөө | Эрэгтэй | Бакалавр | 2011 | Үдийн цай |
| Оролцогч 13 | Хөдөө | Эрэгтэй | Бакалавр | 2004 | Хүнсний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа |

Судалгаанд оролцсон оюутны төлөөлөл

| № | Байршил | Хүйс | Курс | Нас | Сургуулийн харьяалал |
|----|---------|---------|------|-----|----------------------|
| 1 | Хөдөө | Эмэгтэй | 2 | 19 | Улсын |
| 2 | Хөдөө | Эмэгтэй | 2 | 19 | Улсын |
| 3 | Хөдөө | Эмэгтэй | 2 | 19 | Улсын |
| 4 | Хөдөө | Эрэгтэй | 3 | 20 | Улсын |
| 5 | Хот | Эрэгтэй | 2 | 21 | Улсын |
| 6 | Хот | Эрэгтэй | 4 | 24 | Улсын |
| 7 | Хот | Эмэгтэй | 3 | 20 | Улсын |
| 8 | Хот | Эрэгтэй | 2 | 21 | Хувийн |
| 9 | Хот | Эмэгтэй | 3 | 20 | Хувийн |
| 10 | Хот | Эмэгтэй | 4 | 22 | Улсын |
| 11 | Хот | Эмэгтэй | 4 | 20 | Хувийн |
| 12 | Хөдөө | Эмэгтэй | 3 | 21 | Улсын |
| 13 | Хөдөө | Эмэгтэй | 2 | 19 | Улсын |
| 14 | Хөдөө | Эрэгтэй | 2 | 17 | Хувийн |
| 15 | Хөдөө | Эрэгтэй | 4 | 20 | Улсын |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

